

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 7 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

Хүннү гүрэн байгуулагдсаны 2228, Их Монгол улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан МУ-ын Ерөнхийлөгчийн 2019.07.06 өдрийн 127 дугаар зарлигаар Монгол Улсын төрийн үйлчилгээний гавьяат ажилтан цол, тэмдгээр 1, Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор 6, Алтан гадас одонгоор 34, Хөдөлмөрийн хүндэт медалиар 17 шагнууллаа.

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг, аюулт үзэгдлийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, анхааруулах сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор ОБЕГ, Ус цаг уур орчны шинжилгээний хүрээлэнгээс ирүүлсэн урьдчилан сэргийлэх цаг агаарын мэдээг орон нутгийн 2 телевизээр нийт 4 удаа, Онцгой байдлын газрын Sukhbaatar.uridchilansergiileh фэйсбүүк хаягаар иргэдэд цаг үеийн мэдээллийг 3 удаа хүргэн ажилласан байна. Мөн “Болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх” арга хэмжээний удирдамжийн хүрээнд Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт байрлаж буй үерийн далан, хамгаалалтын систем, ус өнгөрүүлэх суваг шуудууны ашиглалтын байдалд үзлэг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цэвэрлэгээ, засвар үйлчилгээний арга хэмжээг зохион байгуулж бэлэн байдлыг хангах урьдчилан сэргийлэх зорилгоор Баруун-Урт сумын Засаг даргад албан мэдэгдэл хүргүүлж тайлан мэдээг авч ажиллалаа. Баруун-Урт суманд 07 дугаар сард объектын дуудлагаар 2 удаа гарч ард иргэдийн 60 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан.

Агентлаг, сумдын хагас жилийн үйл ажиллагааны тайланг хүлээн авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тайланг ЗГХЭГазарт хүргүүллээ.

Хагас жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заримт зорилтын хэрэгжилтийг хангах, ажил эрчимжүүлэх, төрийн албаны сахилга батыг дээшлүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргны албан даалгавар гарган, агентлаг, сумдад хүргүүлээд байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД :

Канадын мерит төсөлтэй хамтран Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтыг 2019 оны 07 сарын 22-27-ны хооронд зохион байгууллаа. Сургалтад сумдын санхүүгийн албаны дарга болон аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтнүүд бусад салбарын төлөөлөл амжилттай оролцож, сертификат гардан авсан.

2019 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж буй ажлуудын тендер сонгон шалгаруулалт, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд Баруун-Урт сумын 960 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажил 30%-ийн гүйцэтгэлтэй, Гүйцэтгэгч Эм Би Би Си ХХК 1250,0 сая.төгрөг, Хүнсний ногооны зоорийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80 %-тай, гүйцэтгэгч Манхан-Уст ХХК 194,0 сая.төгрөгийн санхүүжилтийг хянаж, олгоод байна.

ОНХС-ийн орлогын шилжүүлэг /1-7 сарын өссөн дүнгээр/ төлөвлөгөөгөөр 1826,3 сая.төгрөг шилжиж ирсэн. Үүнээс сумдад 974,0 сая.төгрөг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажлуудын гүйцэтгэлд 700,8 сая. төгрөг, Удирдлагыг болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал 949,0 сая. төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсвөөс 5636,2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч орон нутгийн төсөвт 6129,6 сая төгрөгийн орлого орж, орон нутгийн төсвийн нийт зарлага санхүүжилтанд 10005,3 сая төгрөгийн санхүүжилт хийгдлээ. Үүнээс сумдад санхүүгийн дэмжилгээр 2511,7 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардалд 2215,9 сая төгрөг, соёлын шилжүүлгийн байгууллагуудын зарлага санхүүжилтэнд 1409,3 сая төгрөг, Спорт хорооны зарлага санхүүжилтанд 334,7 сая төгрөг, Засаг даргын нөөц санд 295,0 сая төгрөг, Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 122,1 сая төгрөг, , Удирдлагыг болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх зардалд 751,8 сая төгрөг, татварын буцаан олголтонд 534,9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудад 1829,9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

Улсын төсвөөс сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлгээр 4606,0 сая төгрөг, Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлгээр 9502,1 сая төгрөг, Газрын харилцаа кадастрын тусгай зориулалтын шилжүүлгээр 204,1 сая төгрөг, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газрын тусгай зориулалтын шилжүүлгээр 140,7 сая төгрөг, Эрүүл мэндийн анхан шатны тусламж

үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлгээр 2382,3 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэн байна.

Төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам түргэн шуурхай хийж, хянан баталгаажуулан банк хооронд дамжуулах нөхцөлийг ханган ажиллаж байна.

Эхний хагас жилийн байдлаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн ажлуудаас 10 нэр төрлийн 12.277.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендер зарлагдсан. Үүнээс 7 нэр төрлийн 10,395.0 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Улсын төсвөөс эрх шилжиж ирсэн худалдан авах ажиллагааны явц 71.4 хувьтай байна.

Орон нутгийн төсвөөр хийгдэх ажлуудаас 20 нэр төрлийн 1,815.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний тендер зарлагдсанаас 17 нэр төрлийн 629,3 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаад байна. Тендер зарлагдаад оролцогч ороогүй хүчингүй болсон 1 ажил, тендерийн нээлт хийх хугацаа болоогүй 2 ажил байна.

Өнөөдрийн байдлаар орон нутгийн өмчийн газар дээр зарлагдах худалдан авах ажиллагааны явц 51,7 хувь, эрх шилжүүлсэн ажлын явц 35,7 хувьтай байна.

Худалдан авах ажиллагаа удааширч буй шалтгаан нь ажлын зураг төсөв бэлэн болоогүй, холболтын зургууд хийгдэж байгаа болон бараа, үйлчилгээний тендерүүдийг 7 сараас хойш зарлахаар хугацааг хойшлуулсантай холбоотой.

Орон нутгийн өмчит 12 байгууллагаас үндсэн хөрөнгийн талаар ирүүлсэн санал хүсэлт, холбогдох материалыг судлан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах, акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай 1 тогтоол гаргуулан, хяналт тавин ажиллаж байна. Мөн “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ, 2018 оны жилийн эцсийн хөрөнгийн дүн”-г батлууллаа.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын дагуу 06 дугаар сарын 10-ны өдрөөс 16-ны өдрийн хооронд Сүхбаатар, Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон сумдад 06 дугаар сарын 26-ны өдрөөс 29-ний өдрийн хооронд Баяндэлгэр, Халзан, Уулбаян, Түвшинширээ, Мөнххаан, Түмэнцогт сумдад ажлын хэсэг явж ажиллаа.

Статистикийн хэлтсээс 07 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэн ажилласан. Үүнд:

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2019 оны хагас жилийн танилцуулга, инфографик мэдээллийг бэлтгэн 60 хувь хэвлэн аймгийн удирдлага, сумд, агентлаг, албадад тархаан ажилласан.

Эхний хагас жилийн мэдээг 14 салбарын 372 аж ахуйн нэгжээс цуглуулан Үндэсний статистикийн хороонд 7 дугаар сарын 21-нд бүрэн хүргүүлэн ажиллаа.

2019 оны байшин, орон сууцны тооллогын урьдчилсан бүртгэлийг хөтлөх арга зүйн сургалтанд онлайнгаар хамрагдаж бэлгэлийг ханган ажиллаж байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн 321 иргэний мэдээллийн анхан шатны түвшинд тодруулан хүргүүлэн ажилласан.

Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн талаарх 10 жилийн хугацааг хамарсан 20 бүлгийн 116 дэд бүлэгтэй статистикийн эмхэтгэлийг бэлтгэн хийж хэлтсийн вэб сайтанд /www.sukhbaatar.nso.mn/ байршуулж хэрэглэгчдийн хүртээл болгосон. Мөн Сүхбаатар аймгийн “Хүн ам, өрхийн танилцуулга-2018”, “Хөдөө аж ахуйн танилцуулга-2018”, “Хүн амын амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлт-2018”, “Аж үйлдвэр, барилга, үйлчигээний салбарын танилцуулга-2018” зэргийн бэлтгэн хэлтсийн вэб сайтад байршуулсан.

Санхүүгийн хяналт, аудитын газраас 7 дугаар сард аймгийн Засаг даргын болон албаны даргын баталсан удирдамжийн дагуу 2 объектын санхүүгийн үйл ажиллагаанд, “Нийтийн номын сан”, “Нью Дарьганга” ОНӨААТҮГ, Сүхбаатар сумын ОНХСан, “Биеийн тамир спортын газар” гэсэн нийт 4 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлээ. Одоогийн байдлаар төлөвлөгөөт 1 төсөвт байгууллагад шалгалт хийгдэж байна. Тайлангийн хугацаанд шалгалтаар илэрсэн 106646.4 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч ажиллалаа.

ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2019 оны улсын төсвийн хөрөнгөөр Сүхбаатар аймагт хэрэгжихээр эрх шилжиж ирсэн ирсэн Баруун-Урт сумын 4-р тойргийн хатуу хучилттай авто зам барих, Сүхбаатар сумын сургуулийн их засвар, Уулбаян суманд 240 суудалтай

соёлын төв барих, Түвшинширээ суманд 240 суудалтай соёлын төв барих, Халзан суманд 100 хүүхдийн цэцэрлэг барих, Асгат сумын ЭМТ-ийн лабораторийн барилгыг шугам сүлжээнд холбох ажлын гэрээг тус тус байгуулж ажлыг эхлүүллээ.

Яамд болон холбогдох дээд газруудаас ирсэн албан бичгийн хариуг шийдвэрлэсэн байдал: ЗТХЯ-наас ирүүлсэн эрх шилжиж ирсэн ажлын тайланг холбогдох журмын дагуу гарган ирүүлэх, Аудитын газраас ирүүлсэн тайланд санал өгөх тухай албан бичгийн хариуг тус тус хүргүүллээ.

Иргэн, аж ахуйн нэгжийн газар өмчлөх, эзэмших хүсэлтийг хүлээн авч, аймгийн Засаг даргад уламжлан өмчлөлөөр 28567м² 2,85 га газар, эзэмшлээр 2770 м² 0,27 га газрын захирамжийг гаргуулан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжид захиалагчийн хяналтыг 1-2 удаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй Мөнххаан суманд 240 хүний суудалтай соёлын төвийн барилгын, ажлыг гүйцэтгэгч “Мангал констракшн” ХХК, баруун-урт сум 960 хүүхдийн сургууль барилга гүйцэтгэгч “Эм Би Би Си ” ХХК, Хүнсний ногооны зоорийн барилга гүйцэтгэгч “Манхан уст” ХХК-иудын барилгуудын барилга угсралтын үйл ажиллагаатай танилцлаа. Хяналтын явцад гарч буй алдаа дутагдал, мөн тохирлын гэрчилгээтэй материал түүхий эдийг гарал үүслийн гэрчилгээтэй байх талаар анхаарч ажиллах үүрэг даалгаврыг барилгын ажлын журналын дэвтэр дээр бичиглэл үйлдлээ.

Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид, хийц бүтээцийн бетон шоо-8 элс-1, тоосго-2 дээжийг хүлээн авч нийт 11 дээжид сорилт шинжилгээ хийж дүгнэлт гаргаж хариуг цаг тухай бүрт нь олгосон байна.

Ашиглалтад орсон барилга байгууламжийг БМ-19 маягтийн дагуу 2-р улирлын тайланг мэдээг 3/226 тоот албан бичгээр барилгын хөгжлийн төвд хүргүүллээ.

Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны тушаалаар батлагдсан 33-н маягтын дагуу 2019 оны барилгын материал үйлдвэрлэгч “Дарцагт-овоо” ХХК, “Сэвүүн уудам тал” ХХК 2-р улирлын мэдээг 2/217 тоот албан бичгээр авч БХТөв, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо зэрэг газруудад хүргүүллээ.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 2-р ээлжийн вакцинжуулалт хийхээр аймгийн Засаг даргын 2019 оны А/282 дугаар захирамж гарч Онгон, Наран, Баяндэлгэр, Халзан, Уулбаян, Түвшинширээ сумдын 1835 өрхийн

77631 үхэр, 761723 хонь, 441083 ямаа нийт 1,2 сая толгой мал буюу 90,5 хувьтай хамрагдаад байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн А/370 дугаар захирамжийн дагуу Асгат, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Баруун-Урт, Мөнххаан сумдын 494,0 мянган төл малд вакцинжуулалтад хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар 384,6 мянган төл хамрагдаж вакцины явц 77,9 хувьтай байна.

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори, Хөдөө аж ахуйн их сургуулийн багш, мэргэжилтнүүд ирж мал эмнэлгийн лабораторийн эмч нартай хамтран Мөнххаан, Сүхбаатар, Баруун-Урт сумдаар явж адууны ям өвчний халдварлалтыг тогтоох зорилгоор тандалт шинжилгээнд дээж авч, малчдад сэрэмжлүүлэг мэдээллийг өгч ажилласан.

Био комбинатаас цусан халдварт, галзуу, боом өвчнөөс урьдчилсан сэргийлэх вакцины хүлээн авч олгох хуваарийг гарган батлуулж сумдад олгоод байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулах тухай” А/206 дугаар захирамжийн дагуу халдваргүйтгэлийн ажил хийгдэж байна. Хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 3500 гаруй малын хүүр сэг зэмийг цуглуулж 180,0 мянган м/кв талбай, 350 гаруй айл өрхийн хашаа хорооны 480,0 мянган м/кв, 16 агуулах, зоорийн 95,0 мянган м/кв, бэлчээрийн талбайн 150,0 мянган м/кв талбай, 25 худаг уст цэг, нуур орчмын 30,0 мянган м/кв, өтөг бууцны 160,0 мянган м/кв, хогийн цэгийн 82,2 мянган м/кв, устгалын 35 цэгийн 36,0 мянган м/кв талбай, нийт 1213,2 мянган м/кв талбайд халдваргүйтгэлийг хийгээд байна. Аймгийн Мал эмнэлгийн газар нь Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газартай хамтран аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа мал нядалгааны газруудын эзэн, малын эмч нартай уулзалт зохион байгуулан үүрэг чиглэл өгч нядалгааны газрын хашаа хороо, агуулах, хөргүүр, аймгийн төвийн нэгдсэн устгалын цэгт хогт ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийсэн.

Баруун-Урт сумын төвийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжинд тарьсан модны усалгаа, арчилгаа ургалтын байдлыг тогтоох ажлыг аймгийн Засаг даргын А/302 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 7-р сарын 01- 04-ны өдрүүдэд гүйцэтгэлээ. Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн 9 газарт 3-12 настай 8 төрлийн 18912 ш мод сөөг ургаж байна. Модны төрлийн хувьд 50-60 %-д улиас, хайлаас 40%-д гүйлс, голтбор, шархуйс, далан хальс зэрэг бут сөөгүүд ургаж, амьдралтын байдал 79.9%-тай байна.

Хүннү гүрэн байгуулагдсаны 2228, Их Монгол улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үеэр “Хандлагаа өөрчилж цэвэрхэн наадацгаая” аяныг зохион байгууллаа. Уг аяны хүрээнд БОАЖЯ-наас бүтээсэн 20 видео, аймгийн “Z” фильмээр 2 шторк хийлгэж орон нутгийн BBS, SB телевиз болон цахим сүлжээгээр сурталчлан ажиллалаа. Мөн “1 уут хог, 1 ширхэг сугалаа”, 60ш анонс тарааж, хог хаягдлын зөвлөмж, “Цэвэрхэн наадацгаая”, “Хандлагаа өөрчилье” чөлөнж зарлаж /нийт 618 хүн нэгдсэн/, хоол, хүнсний үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, ААНБ-иуд цаасан уутаар үйлчилж, 910 ширхэг хогийн уутыг иргэдэд тараах ажлуудыг тус тус зохион байгууллаа.

“Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах” журмын дагуу төсөл сонгон шалгаруулах дэд хорооны хурлын бэлтгэл ажлыг хангаж, хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт илэрхийлсэн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн материалыг жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн программд бүрэн шивж оруулж, нийт 2,6 тэр бум төгрөгийн 27 төсөл шаардлага хангасаныг үнэлэн сонгон шалгарсан төслийн жагсаалтыг аймгийн Засаг даргын Захирамжаар баталгаажуулан жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хүргүүлэн ажиллалаа.

Худалдаа аж үйлдвэрийн танхим нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан бөгөөд энэ үеэр 30 гаруй жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнээр зах зээлийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж аймгийн удирдлагууд танхимын удирдлагууд, үйлдвэр эрхлэгчдийн төлөөлөлтэй уулзаж цаашид хамтран ажиллах талаар санал солилцлоо.

Стандарт хэмжилзүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Сүхбаатар аймаг дахь салбар танхим хамтран Худалдагч-Кассчин нярвын сургалтыг зохион байгуулж 40 хүнд худалдагчийн мэргэжлийн үнэмлэх олгоод байна.

Монголын сүү судлалын шинжлэх ухааны холбоотой хамтран “ Хүнсний аюулгүй байдал сүү цагаан идээ боловсруулах технологи”- ийн сургалтыг 07 дугаар 26-27-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад 13 сумын ХАА-н тасаг болон Мал эмнэлгийн үржлийн тасгийн мэргэжилтэн, сүү цагаан идээ боловсруулдаг 41 жижиг дунд үйлдвэр эрхлэгчид хамрагдлаа.

Сум бүр 30 үнээний тасаг байгуулж ажиллах аймгийн Засаг даргын А/369 тоот захирамж гарсаны дагуу 13 суманд чиглэл өгч Дарьганга, Мөнххаан, Баяндэлгэр, Халзан сумдад 10-35 үнээтэй тасаг ажиллуулж эхлээд байна.

“Сүхбаатар хөгжил ҮТП”-ын гүйцэтгэх захирлыг шинээр томилж байгууллагын статус, хөрөнгө санхүүг шийдвэрлэх талаар санал боловсруулах, үйл ажиллагаа явуулж байгаа нэгжүүдийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх, жижиг дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сангийн хөрөнгийг буцаан төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэн хэрэгжүүлж байна.

HD-р гарах 82 суваг Спортын 6 суваг, гадаадын 20 суваг тоон системийн “National” кабелийн телевизийн тоног төхөөрөмж суурилуулан, хэрэглэгч холбоход бэлэн болоод байна. Мөн GPON /Интернэт болон Телефон/ сүлжээний төхөөрөмж Аймгийн ЗДТГазар, Эрүүл мэндийн төвд шинээр тавьж, Эрдэнэцагаан суманд кабель шугамд засвар үйлчилгээ, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Онгон, Наран сумдын болон сумдын ЗДТГазар, Сургууль, Эрүүл мэндийн төвийн сумдад интернэтийн хурд нэмж, шинээр төхөөрөмж тавьсан.

Түвшинширээ сумын 10кВ-ын ЦДАШ-д 5 ш модон тулгуур солих, Өндөрхаан-Баруун-Уртын 110кВ-ын ЦДАШ-ын 32ш тулгуурт газардуулга гагнах, Баруун-Урт дэд станцын радио реле 10кВ-ын гаргалга sel-75А реле шинээр суурилуултын ажлуудыг хийлээ.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2018-2019 онд шинээр баригдаж байгаа барилгуудын мэдээллийг 7 хоног бүр авч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнд: Шинээр баригдаж байгаа Халзан, Мөнххаан сумын Соёлын төв, Уулбаян сумын Хүүхдийн дотуур байр, Соёлын төв, Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Баруун Урт сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгын явцтай газар дээр нь очиж танилцан, Уулбаян Түвшинширээ сумдын соёлын төв, Мөнххаан сумын спорт заалны барилгын ажил эхлээгүй, Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн шинэ барилгын суурийн ухалтын ажил эхэлсэн. Асгат сумын Соёлын төвийн их засварын 1-р хэсгийн ажил дуусаж хүлээлгэж өгөхөд бэлэн болсон.

Сургууль, цэцэрлэгийн удирдлагуудын ээлжийн амралтыг аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулан 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эдлүүлж байна.

Аймгийн Засаг даргын шийдвэрээр зохион байгуулагдаж буй хурдан морины уралдааны явцад уралдаанч хүүхдийн цахим бүртгэл, хамгаалалтын хувцас хэрэгслийг иж бүрнээр нь өмсүүлж аюулгүй байдлыг бүрэн хангахаас гадна даатгалд 100 хувь хамруулж ажиллалаа. Эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 45 удаагийн морины уралдаан зохион байгуулагдсан ба 23 албан ёсны шийдвэртэй уралдаанд давхардсан тоогоор 2973 хүүхэд оролцож 21 хүүхэд мориноос унасны 20 нь эмчийн үзлэгээр гэмтэл, бэртэлгүй нь тогтоогдож эцэг эх, асран хамгаалагчдад нь хүлээлгэн өгсөн бөгөөд 1 хүүхэд эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн.

Соёл, урлагийн байгууллагуудын 2019 оны эхний хагас жилийн тайлангийн хурал зохион байгуулж 13 сумын Соёлын төв, Жаахан шарга театр, Угсаатны зүйн музей, Нийтийн номын сан тайлантай танилцлаа.

Угсаатны зүйн музей түүхт 70 жилийн ойн ажлын хүрээнд Дарьгангын алдарт дархчуулын “Мөнгөн урлалын Нандин өв” үзэсгэлэнг Улаанбаатар хотноо 14 хоног гаргалаа.

Төв аймагт зохиогдсон засмал замын уралдааны дугуйны Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 3 алт медаль, 5 мөнгөн медаль, 1 хүрэл медаль хүртсэн.

Улаанбаатар хотод зохиогдсон өсвөрийн хөл бөмбөгийн УАШТэмцээнд нийт 55 багийн 600 гаруй тамирчид өрсөлдөж манай эрэгтэй, эмэгтэй тамирчид шилдэг 8-т шалгарсан.

Харааны бэрхшээлтэй иргэдийн Хонхот бөмбөгийн УАШТ Эрдэнэт хотод зохиогдсон ба тус тэмцээнд 32 багийн 200 гаруй тамирчид оролцсоноос эмэгтэй баг тамирчид 8 дугаар байрт шалгарсан.

Хэнтий аймагт болсон Зүүн бүсийн Хонхот бөмбөгийн тэмцээнд эмэгтэй баг тамирчид алтан медаль хүртсэн.

2019 оны 09 дүгээр сарын 06-аас 09 дүгээр сарын 15-д болох Хүүхдийн спортын V-р наадамд оролцох баг тамирчид бэлтгэлээ хийж эхэлээд байна.

07-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 898 иргэнээс эмэгтэй 398, бүртгэлтэй ажилгүй иргэн 693 иргэнээс, эмэгтэй 311 иргэн байна. 442 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 431 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 302 иргэн буюу 70 % нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 423 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

86 иргэнийг ХЗЗ-н мэдээллийн нэгдсэн санд ажил хайгч иргэнээр шинээр болон шинэчлэн бүртгэж, 14 иргэний ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг нийгмийн даатгалын хэлтэст гаргаж ажилласан.

7 дугаар сарын 02-ны өдөр Баяндэлгэр суманд ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээний хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмжийг бүлэгт хүлээлгэн өгсөн.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний хүрээнд 7 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэв.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Түмэнцогт, Халзан, Наран, Баруун–Урт сумдад нийт 8 малчинд мал олголоо. Нийтийг хамарсан ажлаар 4 сумын 4 төслийн 40 иргэнд 11,2 сая төгрөгийг зарцуулсан. Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээнд Баруун-Урт сумын 6 иргэн бүлэг болж одоогийн байдлаар 8 дахь өдрөө нийтийн эзэмшлийн болон хувийн газруудаар зэрлэг зулгаах ажлыг хийж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 12,236.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг төвлөрүүллээ.

Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд 70, 753.7 мянган төгрөгийг санхүүгийн бичиг баримтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрт 75 иргэнд 5,787.0 мянган төгрөг
- Ажлыг байрыг дэмжих хөтөлбөрт 50 иргэнд 26,290.0 мянган төгрөг
- ХБИ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 708.0 мянган төгрөг
- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 55 иргэнд 36,410.0 мянган төгрөг
- Үйл ажиллагааны зардалд 1,558.7 мянган төгрөг

Жижиг зээлийн төсөлд дэмжигдсэн 6 иргэнтэй “Ажлын байр бий болгох гэрээ”-г байгуулан ажиллалаа.

2019 онд нийгмийн халамжийн орон нутгийн төсвөөс 135,5 сая төгрөг, улсын төсвөөс 9391,9 сая төгрөг нийт 9527,4 сая төгрөгийг зарцуулагдахаар тусгагдсан

байна. 07 дугаар сарын байдлаар халамжийн тэтгэвэрт 1.420.447 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 484.8 сая төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 306.5 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээнд 112.4 сая, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт 216,6 сая, жирэмсэн эхийн тэтгэмж 175.1 сая, хүнс тэжээл хөтөлбөрт 601.4 сая, орон нутгийн төсвөөс 52.6 сая төгрөгийн санхүүжилтийг авсан. Халамжийн тэтгэвэр 1251 иргэнд 1,172.144 сая, Нөхцөлт мөнгөн тусламж 986 иргэнд 396,8 сая, Амьжиргааг дэмжих дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 815 иргэнд 223,6 сая, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөд 421 иргэнд 62,9 сая, Хүнс тэжээл хөтөлбөрт 7181 иргэнд 516,9 сая, Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 16 иргэнд 19.2 сая, ОНОТХҮйлчилгээ 36 иргэнд 21,9 сая төгрөгийг олгоод байна. Ахмад дайчдад сар бүр тусламж олгох, Улсын баатар, Монгол Улсын Үндсэн хуулийн хэлэлцэж баталсан /1990-1992 он/ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн ахмад настан, Хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон 14 ахмад настанд 14.5 сая, Эхийн алдар “I, II” одонтой 5024 эхчүүдэд 687,1 сая, цалинтай эхийн тэтгэмжид 3656 эхэд 893.0 сая, өрх толгойлсон 106 эхэд 61.0 сая, 65 ба түүнээс дээш настай 2375 ахмад настнуудад 195.8 сая төгрөгийн насны хишгийг олгоод байна. Үүнд: 65-69 насны 977 ахмад настанд 48.8 сая төгрөг, 70-79 настай 943 иргэнд 75.3 сая төгрөг, 80-89 настай 419 иргэнд 62.7 сая төгрөг, 90-ээс дээш насны 36 иргэнд 9.0 сая төгрөгийг тус тус олгоод байна. Тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой өргөдөл, гомдол гараагүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 1 удаа хуралдаж нийт 9 хүүхэд орсон. Үүнээс: 1 хүүхэд заалт таарахгүй хасагдсан, 1 хүүхэд эдгэрсэн тул хасагдсан, 1 хүүхэд шинээр орж 6 хүүхэд сунгагдсан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 7 дугаар сард 1383 өрхийн 6706 иргэн хамрагдаж байна. Баруун-Урт сумын цахим талоны шинэчлэлийг татан авч тулгалт хийн 7 дугаар сард олгох 659 өрхийн 3220 иргэний 39816000 төгрөг, Эрдэнэцагаан сумын 197 өрхийн 995 иргэнд олгох 12304000 төгрөгийн хүнсний талоны санхүүжилтийг захиалж санхүүжүүлсэн. Хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх “Ундрах” супермаркет, “Хаан жимс”, “Баялагийн ундрах”, “Чандмань дэлгэр ундрах” хүнсний дэлгүүрүүдэд 07 дугаар сарын худалдан авсан бүтээгдэхүүний бүртгэлийг өрх бүрээр хүнсний эрхийн бичгийн програмтай тулган хэвлэж гаргасан. Баруун-Урт сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхийн жагсаалтыг сар бүр хүнсний эрхийн бичгийн онлайн программын бодолттой тулгаж бичилт хийх хувиар гарган хувийн хэрэгт олголтын бичилтийг хийж баталгаажуулсан. Тус сумын

хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн 2,4,6-р багийн 167 өрх, 1,3,5,7,8,9 дүгээр багийн 492 өрхийг өөрөө хариуцан хувийн хэрэгт баяжилтыг хийж, хувийн хэргийн бүрдлийг тулгаж хугацаа дууссан иргэний үнэмлэх, итгэмжлэл, лавлагаа хүчингүй болсон 2 өрхийн 13 иргэний баримт бичгүүдийн бүрдүүлэн авсан. Мөн хүнсний эрхийн бичгийн журмын 1.9, 1.10 дахь заалтын дагуу тодорхойлолт холбогдох баримт бичгийг хувийн хэрэгт авч хавсаргаж байна. Хүнсний эрхийн бичгийн журмын нөхцөл шалгуурыг хагас жил тутамд “Өрхийн гишүүн-иргэний үнэлгээний хуудас”-аар өрхүүдийг үнэлэхэд 0-50 оноо буюу тухайн өрхөөс нөхцөл шалгуур хангаагүй иргэнийг түдгэлзүүлэх үнэлгээтэй 444 өрх, 50-75 оноо буюу анхааруулах үнэлгээтэй 574 өрх, 75-100 оноо буюу хангалттай үнэлгээг 385 өрх авсан байна.

Баруун-Урт суманд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй өрхүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, мэдээллийг тулгах шаардлагатай 38 өрхийн жагсаалтад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Ажлын удирдамж” гарч ажлын хэсэг томилогдон 2019 оны 06 дугаар сард ажилласан. Тус сумын 38 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийхээс 11 өрх эзгүй, хаягандаа амьдраагүй байсан тул 27 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж хэлэлцсэнээс 22 өрхийн үйлчилгээг 7 дугаар сараас зогсоохоор ажлын хэсэг шийдвэрлэлээ. 7 дугаар сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдах эрх үүссэн 5 өрхийг сумдын амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлж хамруулахаар шийдвэрлэж үйлчилгээг олгож эхлээд байна

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/317 дугаар тушаал, Эрүүл мэндийн газрын даргын А/51 тоот тушаалын дагуу баяр наадмын өдрүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор эрүүл мэндийн салбар хариуцлагатай жижүүрийг томилон 8 цаг тутамд ЭМЯ-д мэдээ мэдээллийг хүргүүлэн ажиллалаа. Баяр наадмын өдрүүдэд эрүүл мэндийн салбарын нийт 193 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд 24 цагийн турш эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан. Мэдээг ЭМЯ-нд 2019 оны 07 сарын 9 өдрийн 08:00 цагаас 2019 оны 07 сарын 16-ны өглөөний 08:00 цаг хүртэлх хугацаанд 8 цаг тутамд ЭМЯ-ны Naadam2019@moh.gov.mn цахим хуудсанд байршуулан тухай бүр 11-323002 утсанд мэдээллийг өгч, аймгийн онцгой байдлын газарт мэдээлсэн байна

Баяр наадмын үеийн хариуцлагатай жижүүрийн чиг үүрэг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, иргэдэд осол гэмтэл хоолны хордлого халдварт өвчнөөс

сэргийлэх мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх талаар 7 дугаар сарын 8-ны өдөр 82 эмч эмнэлгийн мэргэжилтэнд цахим хурал, сургалтыг зохион байгуулсан.

Орон нутгийн BBS телевизтэй хамтран хоолны хордлого, наршилт, осол гэмтлээс сэргийлэх 4 төрлийн шторктийг 36 удаагийн давталтайгаар нэвтрүүлж цахим хуудсанд 8 төрлийн мэдээлэл байршуулсан

Аймгийн баяр наадам болохтой холбогдуулан иргэдийн дунд халдварт өвчин ялангуяа гэдэсний халдвар гарахаас сэргийлэх зорилгоор аймгийн баяр наадмыг зохион байгуулах комисстой холбогдож, Мал эмнэлгийн албатай хамтран наадмын талбайн эргэн тойрон, морь барианы газар, хоолны гэрүүдийн орчны газрын хөрс, 5 ариун цэврийн байгууламжид халдваргүйтгэлийг 25000 мянган мкв талбайд 1:2000 туберкил бодисоор хийлгэж хяналт тавьж ажилласны үр дүнд хоолны хордлого, халдварт өвчин, гэдэсний халдвар зэрэг олныг хамарсан ноцтой тохиолдол бүртгэгдээгүй.

Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 тоот албан даалгаврын хүрээнд тарваган тахлын дархлаажуулалтыг 7 дугаар сарын 1-ээс эхлэн тархвар судлалын заалтаар ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан АНЭ, МХГ, ОБГ, Цагдаагийн газрын 152 ажилчин, албан хаагчдыг дархлаажууллаа. Хамралт 79% дархлаажуулалт хийгдсээр байна.

Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд 35.0 сая төгрөгийн эм, хэрэгслийг татан авч Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд хуваарилан олгоод байна.

Эрүүл мэндийн даатгалын тасагтай хамтран 3 Өрхийн эрүүл мэндийн төв, Баруун- Урт хотод үйл ажиллагаа явуулж байгаа 7 хувийн хэвшлийн эмийн сангуудад хамтарсан явцын хяналт хийн арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

ДЭМБ, ЭМЯ-аас эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, сэргээн засах эмчилгээний нөхцөл байдлын үнэлгээ аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хийлээ.

Дарьганга сумын эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг ашиглалтад хүлээн авлаа.

Дэлхийн хепатитийн эсрэг өдрийг жил бүрийн 07 дугаар сарын 28-нд ДЭМБ-ын гишүүн орнууд уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ жил “Хепатитийг устгах ажилд хувь нэмэр оруулцгаая” уриан дор 7 сарын 26-ны өдөр зохион байгуулж байгаа бөгөөд Сүхбаатар аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг,

сумын өрхийн эрүүл мэндийн төв нийт 17 эрүүл мэндийн байгууллага тэмдэглэн өнгөрүүллээ. Баруун-Урт сумын хэмжээнд Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Эрүүл мэндийн даатгалын тасаг, Эм ханган нийлүүлэх байгууллага, хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүд хамтран “Хепатитийг устгах ажилд хувь нэмэр оруулцгаая” өдөрлөгийг Биеийн тамир спортын газрын зааланд зохион байгуулж 250 гаруй иргэдэд элэгний хепатит вирусийн талаарх ойлголт, халдвараас урьдчилан сэргийлэх арга, сайн дурын дархлаажуулалтын талаарх мэдээлэл, 150 гаруй хүнд В, С вирусийн шинжилгээ, 47 хүн хэвлийн ЭХО, вирусийн идэвхжилтэй хяналтын 17 хүн үзлэгт хамрагдан 8 хүнд В,С вирусийн хөнгөлөлтэй эм бичиж, Эрүүл мэндийн даатгалын тасаг иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулан, хувийн хэвшлийн эм ханган нийлүүлэх байгууллага, хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагааг танилцуулан оролцсон.

Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран “1 насны ойн баяр” арга хэмжээг зохион байгуулан 1 ой хүрч буй хүүхдүүдийн эцэг эх асран хамгаалагчдад хүүхдийн хооллолт, ЭХЭМДэвтрийн хөтлөлт ач холбогдол, өсөлтийн муруй, товлолын дархлаажуулалтын талаарх сургалт хийж, 6 төрлийн хүүхдийн нэмэгдэл хоол эцэг эхчүүдээр бэлтгэн, хамтран ярилцаж зөвлөгөө өгч ажиллаа.

Эрүүл хооллолт-Эрүүл амьдрал цуврал 2 нэвтрүүлгийг орон нутгийн BBS телевизтэй хамтран бэлтгэсэн

ТАВ. БАТЛАН ХАМГААЛАХЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Монгол Улсын “Цэргийн албаны тухай” хуулийн 31 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 85 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулах хаах болзол хангасан иргэдэд зохиох төлбөрийг тогтоож одоогоор төрийн сангийн тусгай дансанд 9 200 000 төгрөгийг төвлөрүүлээд байна.

Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар орон нутгийн хэмжээнд иргэдэд түргэн шуурхай хүргэж алба хаасан жилийн архивын лавлагаа 5, хугацаат цэргийн албанаас түр чөлөө хүссэн 1 өргөдлийг холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлсэн.

Цэргийн штабыг шалгаж үнэлэх зааврын дагуу хугацаат мэдээ тайланг цаг хугацаанд нь холбогдох дээд байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

ЗУРГАА.СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭ;

1. Асгат сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Үндэсний их баяр наадмыг Аймгийн Засаг даргын захирамжаар 2019 оны 7 сарын 3-4 хооронд тэмдэглэн өнгөрүүлээ. Баяр наадмын хөтөлбөрийн дагуу 8 насны 512 хурдан морь уралдуулж, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган даатгал, хамгаалалтын иж бүрэн хувцастай уралдааны замд гаргаж, ямар нэгэн эрсдэл гараагүй болно. Үндэсний 64 бөх барилдаж сумын “Заан” цолтон төрсөн. Сур харвааны төрөлд 6 сумын эрэгтэй, эмэгтэй харваачид хүрэлцэн ирж оролцсон. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу оюутан, залуучуудын 4 төрлөөр “Спортын наадам”-г зохион байгуулж 4-н багийн 128 тамирчид оролцож шилдгүүдээ тодруулан, үдшийн цэнгүүнийг зохион байгууллаа.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Орон нутгийн байгууллагын санхүүжилт 24 сая төгрөг, ТЗШ-ийн санхүүжилт 36 сая төгрөг, зарлагын гүйлгээ 48 сая төгрөг гарсан. Хагас жилийн санхүүгийн тайлан, 2020 оны төсвийн төслийг аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлээд байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Төл малыг Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга 90% -тай явагдаж байна. Өлзийт багийн 61-н малчин өрхийн 9886 төл мал, Дөхөм багийн 34 өрхийн 14322 төл мал, Их уул багийн 67 өрхийн 18500 төл мал шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад бүрэн хамрагдаад байна. Малын угаалгыг Зээрд, Урд хөтөл, Дөхөм, Далт зэрэг газар хийгдэх төлөвлөгөөг гаргаж бэлтгэл ажил хийгдэж байна. Мөн явуулын ваннид угаалга хийхээр ажиллаж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн төвийн амбулатори, эмийн сангийн дулааны холболтыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 64 сая төгрөгийн засварын ажлыг эхлүүлээд байна.

Итали улсын АЗИА төслөөр сургуулийн дотуур байрны дээврийн засварыг 170 сая, гал тогооны хэрэгсэл, ус цэвэршүүлэх төхөөрөмжийг 70 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварын ажил эхлэн 20%-тай явж байна.

65-аас дээш насны 71 ахмадад улсын баяр наадмаар насны хишгийг бүрэн олгох ажлыг шуурхай зохион байгуулан ажилласан.

Зорилтот бүлгийн 10 өрхийг бүлээр ногоо тарих төсөлд хамруулан 1500 мкв талбайд төмс, хүнсний ногоо тариулан ногооны талбайн зэрлэг түүлгэх, тариалсан ногоогоо арчилж тордох ажлуудыг зохион байгуулан ажиллалаа.

2.

Бар

уун-Урт сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх ажлын хүрээнд нийт 352 иргэнд шаардлагатай тодорхойлолтыг гарган өгч төрийн үйлчилгээг шуурхай хүргэж ажиллалаа.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Худалдан авах ажиллагаа болон хөрөнгө оруулалттай холбоотой цаг үеийн мэдээллийг мэдээллийн самбар, baruun-urt.su.gov.mn, khural.gov.mn сайтаар мэдээлж ажиллаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг Тогтвортой амьжиргаа 3 төслийн газраас 39 үзүүлэлтээр үнэлгээг хийсэн.

Сум хөгжүүлэх сангаас хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зээлийн эргэн төлөлтөд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Харьяа төсөвт байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд эхлэн, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна. Үүнд:

Одкон хотхоны дундах зам талбайн тохижилтын ажлын гүйцэтгэгчээр 54,9 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн Шинэсоёл констракшн ХХК шалгарч тус компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 20%-тай,

Гэр хорооллын хог зөөврийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд ангилдаг хогийн сав хийх ажлын гүйцэтгэгчээр 36,1 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн Жавхланхүслэн ХХК шалгарч тус компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 40%-тай,

Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажлын гүйцэтгэл 70%-тэй,

Агропарк шинэчлэн байгуулах ажлын гүйцэтгэл 80%-тай

Нэг цэгийн үйлчилгээний засварын ажлыг Ай ди си проперти ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 90%-тай

Нарлаг хорооллын талбайн тохижилтын ажлын гүйцэтгэгчээр 84,6 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн Шарга ХХК компани шалгарч гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлээд байна.

Сумын ОНХС-гийн санхүүжилтээр зам засварын ажил нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 2 удаа зарлагдаж тендер амжилтгүй болж тус ажлын гэрээг орон нутгийн Дарцагт овоо ХХКомпанитай шууд гэрээ байгуулан ажиллаж байна.

Гүн өрмийн худаг гаргах ажлыг Төв дриллинг ХХКомпанитай 20,0 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна

Сумын орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нэгдсэн камержуулалтын ажилд 15,0 сая төгрөг зарцуулаад байна.

1-р багийн ажлын алба, Зэвсэгт хүчний 338-р цэргийн ангитай хамтран “Мандал хороолол” болон Уртын голын дагуух тарьсан модонд арчилгаа усалгаа хийж, 2 машин буюу 5 тн хур хогийг цэвэрлээ.

Баруун-Урт сумын ЗДТГазраас Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазартай хамтран төвийн багуудын гудамж талбайд хаягдсан машины сэг, хур хогийг ачиж цэвэрлэлээ.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын “Нийтийг хамарсан ажил”-ын хүрээнд Баруун-урт сумын ажил хөдөлмөр эрхлээгүй, зорилтот бүлгийн 10 иргэнийг түр ажлын байраар хангаж цалинд 2800000 төгрөгийг зарцууллаа.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Аймгийн ГБХЗХГ-с зохион байгуулсан “Гэр бүлийн харилцаанд эмэгтэйчүүдийн оролцоо” хэлэлцүүлэгт Баруун-Урт сумын 9 багийн зорилтот бүлгийн 90 эмэгтэйг хамруулж “Гэр бүлийн тухай”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулиар мэдлэг олгож, тэдний мэдлэг мэдээллийг зохих түвшинд нэмэгдүүлж ажиллав.

Хурд хамтлагийн санаачилгаар, Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан "Хайртай" аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн өсвөр насны хүүхдүүд болон хүүхэд хүмүүжүүлэх монгол ухаан эцэг эхчүүдэд зориулсан сургалтад Баруун-Урт сумын 47 иргэнийг хамруулж зохих үүрэгтэйгээр оролцлоо.

3. Баяндэлгэр сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Сумын баяр наадмыг сумын засаг даргын А/80 тоот захирамжаар 07 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгууллаа. Баяр наадмыг тусгай хөтөлбөрийн дагуу наадам зохион байгуулах журам гаргаж мөрдөж ажилласнаар баяр наадмын үйл ажиллагаа амжилттай явагдаж нийт 6 насны 450 гаруй морь уралдаж, 64 бөх барилдан сумын начин-1, сумын заан-1 төрөн гарсан. Үндэсний шагай, сурын харвааны төрөлд оролцох сонирхогчдын оролцоо идэвх өмнөх жилүүдээс дээшилсэн байна. Баяр наадмын баярын хурлыг зохион байгуулж ажил үйлсээрээ шалгарсан 30 гаруй иргэнд шагнал гардуулж хүндэтгэл үзүүлсэн. Үүнд: Засгийн газрын шагналаар 11, аймгийн шагналаар 4, сумын шагналаар 14, төрийн бус байгууллагын шагналаар 6, төрийн дээд шагнал алтан гадас одонгоор 5, хөдөлмөрийн хүндэт тэмдгээр 2 иргэн тус тус шагнагдсан.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ. Статистикийн байгууллагад сарын мэдээг бүрэн дамжуулсан. Орон нутгийн төсвийн байгууллага, Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтийг хуваарийн дагуу бүрэн олгосон. Төсөвт байгууллагын хөрөнгө ашиглалтын судалгаа хийж аймгийн төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөллийг орон нутгийн төсвийн байгууллагууд бэлтгээд санхүү төрийн санд нэгтгүүлэх ажил хийж байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын ОНХСангийн 9,5 сая төгрөгийн санхүүжилтээр Жүдо бөхийн дэвжээтэй болж бэлтгэл сургуулилт, Цайрт менираль ХХК 50,0 сая төгрөгийн санхүүжилтээр нэгдсэн хогийн цэгийг цэгцэлж эзлэх талбайг 20 га –гаар багасгасан, аймгийн байгаль орчны газрын 2,0 сая төгрөгийн санхүүжилтээр хогийн цэгт харуулын байрыг барьж, 1 иргэнийг ажлын байртай болгосон, хог зөөврийн авто машины их засварт ЗДТГ-ын байгаль хамгаалах хөтөлбөр зориулалтаар 3000000 /гурван сая/ төгрөгөөр иргэн М.Ганбат, сумын төвийн гудамжны гэрэлтүүлгийн ажлыг 6000000 /Зургаан сая/ төгрөгөөр Талст бүлгийн ахлагч Д.Батнасан, Цамхаг

гэрэлтүүлгийн ажлыг алсын Солонго ХХК-тай тус тус гэрээ байгуулан худалдан авах ажиллагааны ажлыг гүйцэтгэсэн, зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 35,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн хуучин барилгын засварын ажил, баяр наадмын талбай барих ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу санхүүжилт 40,0 сая төгрөг зэрэг ажлууд хийгдээд байна.

Сумын баяр наадмаар Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас гаргасан уриалгын дагуу “Хандлагаа өөрчилж- Цэвэрхэн наадацгаая” уриан дор үйлчилгээ явуулж байгаа 11 цэгт хяналт шалгалтыг хийж, хурдан морьдын 450 гаруй мандат дээр уриалгыг хэвлүүлж сурталчлан таниулсан.

ХХААГазрын мэргэжилтэн, МХГазрын байцаагч, сумын ХАА-н тасгийн мэргэжилтэн нар үлийн цагаан оготнотой тэмцсэн талбайг шалгаж ажлын гэрээний биелэлтийг дүгнэсэн.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

174 ахмад настанд 14060,0 сая төгрөгийг насны хишгийг олгон, аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралтад 36 ахмад настан амрааж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан 60 өрхөд 3536,0 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг олгоод байна.

Зохион байгуулалттай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжиж ноос хяргагч, арьс элдэгч зэрэг 3425,0 төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч зорилтот өрхийн 7 иргэнийг бүлэг болгон, бүлгийн 2 иргэнийг Улаанбаатар хотод сургалтад хамруулж үйл ажиллагаагаа явуулж байна.

Урлаг, соёлын 6 үйл ажиллагаа, уралдаан тэмцээн зэрэг 4 үйл ажиллагаа явуулж 800 гаруй иргэнийг хамруулан ажиллаа.

Үндэсний өв, соёлоо дээдлэн сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх биет бус өв тээгчдийг илрүүлэн урамшуулах зорилгоор “Дээлтэй монгол”, “Сайхан монгол хувцастай гэр бүл” шалгаруулах тэмцээн, монгол адууны соёлыг хөгжүүлэх дэлгэрүүлэх чиглэлээр “Уурга шүүрэх” тэмцээн, Монгол бүсгүйн намба төрхийг харуулсан “Урт үстэй бүсгүй” шалгаруулах тэмцээнийг тус тус зохион явуулсан.

Номын сангаар 78 иргэн үйлчлүүлж, 125 ном, хэвлэл гэрээр олгон, 23 иргэнд мэдээлэл, лавлагаа өгч ажиллаа.

“Цагаан булаг” хүүхдийн сувиллыг 1, 2 дугаар ээлжээр ажиллуулж 67 хүүхэд хамрагдлаа.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Баяр наадмаар нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй аж ахуй нэгж, иргэдэд эрүүл ахуйн чиглэлээр мэдээлэл зөвлөмж өгч хяналт тавьж ажиллаа. Мөн хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлын талаар уяачид болон эцэг эхчүүдэд мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан.

Зорилтот өрхийн 26 иргэнд нийгмийн халамжийн тухай хуулийн талаар мэдээлэл сургалтыг зохион байгуулсан.

Дарьганга сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 2019.07.01 нд хуралдаж, бүсчилсэн хөгжлийн бодлогод санал хүргүүлэх асуудлыг хэлэлцэн дараах санлыг гарган хүргүүллээ.

а/. Жишиг сум болгоход 6 тэрбум төгрөгийг /2020-2022 онд / айл өрхийг цэвэр ус, дулаан халаалтад холбох,

б/. 50 тн-ын усан сан барих, 2,0 мвт-ын халаалтын 2 зуух шинээр барих.

в/. Хатуу хучилттай авто зам 168 км-ийг 2021-2023 онд 70 тэрбум төгрөг

г/. 24 айлын орон сууц барих /2023-2024 онд / 1,5 тэрбум төгрөг

д/. Сумыг тойрсон хашлага барих 2020-2021 онд 1 тэрбум төгрөг

е/. Шилийн богдын орчны тохижилт 2021-2023 онд 1,5 тэрбум төгрөг бүгд 80 тэрбум төгрөг.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сумын Засаг даргын захирамжаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шууд гэрээ байгуулах зарчмаар хийгдсэн дараах ажлуудын санхүүжилтийг шийдвэрллээ.

1. Малын тарилгын хашаа 1, 2, 3 дугаар багт барих ажилд 9 сая төгрөг

2. Багийн төвийн байрыг 1, 3 дугаар багт барих ажилд 40 сая төгрөг

3. Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны засварын ажилд 4,903,400 төгрөг

4. Автомашинаас төлбөр хураамж авах цэгийг байгуулахад 9800000 төгрөг /гүйцэтгэгч байгууллага нь УБ хот “Эрдэнэ-Уул ТЭХ” ХХК/

5. Эрүүл мэндийн төвийн явуулын амбулаторын үзлэгт 5 сая

6. Сумын төвийн ундны усны 2 худагт автомат худгийн иж бүрэн тоног төхөөрөмж суурилуулахад 9,900,000 төгрөг / гүйцэтгэгч нь УБ, “Баялаг говь” ХХК/

7. Үндэсний баяр наадмыг тэмдэглэхэд 5 сая төгрөг, нийт 83,603,400 төгрөг
Сумын Засаг даргын нөөц сангаас 1,595,000 төгрөгийг

а/. Сумын төвийн усалгаатай ногооны талбайд бүлгээр ногоо тарих ажилд 610000 төгрөгийн ногооны үр авахад,

б/. 2019 оны 5 дугаар сард болсон гамшигт үзэгдлийн хохирол барагдуулахад 985,900 төгрөгийг тус тус зарцууллаа. Мөн сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 50 үнээний сүүний тасаг байгуулах ажилд 5,610,100 төгрөгийг зарцуулсан.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын Засаг даргын А/35 дугаар захирамжаар ажлын хэсэг томилж, орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэх ажлыг хийсэн. Нийтдээ 2 удаагийн устгалаар 668 сэг зэмийг цуглуулсан ба устгал хийх ажлыг 57 хүн гүйцэтгэсэн. Аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран “Дүк” машинаар 25 тн ус татан авч, 2,3 км урттай 0,8 км өргөнтэй хогийн цэгт давтан ариутгал халдваргүйтгэлийг хийж, 3 малын эмч ажиллалаа. Дээрх ариутгалыг малын түүхий эдийн 2 цэгт, малын 60 хашаа саравч, 28 уст цэгт хийлээ.

Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний тусгай захиалгат бүтээгдэхүүний хэрэгжилтийг хангах зорилгоор “50 үнээний сүүний тасаг”-ажиллуулж, 10 хоногоор 3 ээлжийг ажиллуулж байгаа бөгөөд 1-р ээлжид Цэцэрлэг, 2-р ээлжид Мөнгөн хуримтлалын бүлгийн гишүүд, иргэд, 3-р ээлжид ЕБС-ийн ажилчид ажиллаж байна.

1-р ээлжийнхэн : 1/. Амттай ааруул 25 кг , 2/. Монгол архи 10л , 3/. Бяслаг 4ш, 4/. Өрөм 16 тогооны өрөм , 5/. Айргийн тос 2.5 кг, 6/. Хусам 1кг, 7/. Мангир 17шил зэргийг 10 хоногт бэлтгэв.

2-р ээлжийнхэн: 1/. Амттай ааруул 30 кг, 2/. Өрөм 11кг, 3/. Нэрмэл архи 37 литр, 4 /. Аймгийн тос 1 кг-ыг тус тус бэлтгээд байна. Нийтдээ : Амттай ааруул 55 кг, нэрмэл 47 л, өрөм 27 кг-ыг бэлтгэв.

Улсын баяр наадмаар “Цэвэрхэн наадацгаая хандлагаа өөрчилъе” аяныг зохион байгуулж, наадмын 2 өдөр “1 уут хог 500 төгрөг” уриалга гаргаж хүүхэд багачуудад нэг удаагийн хогийн уутыг тарааж нийт 120 ш уут хог бөөгнүүлж 60,000 төгрөг зарцуулсан. Мөн баяр наадмын дараагаар 3 хүнийг бээлий маск хогийн шуудайгаар хангаж хог тээвэрлэх зориулалтын 3 дугуйт тэвштэй мотоциклд

10 литр бензин хийж өдрийн 25000 төгрөгөөр цалинжуулж 1 өдрийн турш наадмын талбайн эргэн тойрны хогийг цэвэрлүүллээ. Нийт 120,000 төгрөг зарцуулсан болно.

Усны менежментийн төлөвлөгөөний дагуу Дарьганга, Наран, Онгон сумдын нутагт Зэрлэг ан амьтанд зориулж худаг гаргах ажлын хүрээнд “Дунар-од ХХК”-д газрын байршил солбилцолыг гаргаж хүргүүлээд байна.

Сумын “Нью-Дарьганга” хүүхдийн зуслангийн нэг ээлжийг “ЭКО бүлэг”-ийн сурагчдаар бүрдүүлж, 7-р сарын 01-нээс 7 хоног байгалийн аялал жуулчлалын сургалт, танилцуулгыг зохион байгуулж 100 гаруй хүнийг хамруулсан.

Аялал жуулчлалын бүсэд их цэвэрлэгээ хийж 4 тн хогийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлж, Ганга нуурын орчинд эко нойлыг бий болгосон.

Тарвага нутаглах орчинд тандалт эргүүлийг хийж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 3 иргэнд худалдаа үйлчилгээний чиглэлээр 12 сая төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатай, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтөө олголоо.

Үндэсний баяр наадмын өдрүүдэд ЭМТ-нь өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллан, алсын дуудлага 9, ойрын дуудлага 62 ирснийг цаг алдалгүй түргэн шуурхай арга хэмжээ авсан. Хилийн цэргийн 7 дугаар заставын 20 албан хаагчдаас В, С вирус, сахар, холестрины шинжилгээг авч, эрүүл мэндийн чиглэлээр мэдээлэл хийлээ. ЭМТ-ийн шинэ барилгын нээлтийн үйл ажиллагааг 7-р сарын 31-нд зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаад байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт, шинэчлэлтийн талаарх хэлэлцүүлгийг суманд зохион байгуулах ажлын хэсэг нь Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөх Р.Жадамбаагаар ахлуулан суманд ажиллаж, 51 иргэдтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэ үеэр 4 иргэн санал хүсэлт тавьж, асуултад хариулт авлаа. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан “Сургагч багш” бэлтгэх онлайн сургалтад сумын Засаг даргын Тамгын газрын дарга, хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нар аймагт очиж оролцсон. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар иргэд, төрийн

албан хаагчдад 7-р сарын 17-нд мэдээлэл хийж 18 төрийн албан хаагч, 9 иргэн хамрагдлаа.

Сумын худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд дараах хууль тогтоомжоор сурталчилгаа, мэдээллийг газар дээр очиж зохион байгууллаа. Үүнд:

а. Аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгавар буюу Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоолоор “Эх оронч худалдан авалтын жил” болгон зарласантай холбогдуулан дотоодын үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилгоор ажиллах үүргийг хүлээн авч, хамтран ажиллах тухайгаа танилцууллаа.

б. Засгийн газрын 2019.02.27 ны өдрийн 90 дүгээр тогтоолоор батлагдсан 155 нэр төрлийн барааны жагсаалтыг танилцууллаа.

в. Монгол улсын “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн хүрээнд “Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгонд тавих шаардлага”, “Нийлэг гялгар уутыг хэрэглээнээс халъя” зэрэг гарын авлага тархаасан.

Бүсчилсэн хөгжлийн бодлогод 6 саналыг эрэмбэлэн цэгцэлж, сумын ИТХ—ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн, шийдвэр гаргуулж, аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр “Хүүхэд ба эрүүл мэнд” сургалтыг 12 хүнд зохион байгууллаа.

4. Мөнххаан сумын сарын ажлын товч мэдээ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Сумын үйл ажиллагааны хагас жилийн тайланг 7 үзүүлэлтээр гарган аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлэн ажилласан. ТЗУХ-ээс ирүүлсэн 2 судалгааг цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Сумын баяр наадмын комиссыг Засаг даргын А/74 тоот захирамжаар томилон, нарийвчилсан төлөвлөгөөг гарган баяр наадмын үйл ажиллагаа зохион байгуулалттай сайхан болж өнгөрлөө. Баяр наадмаар 6 насны 300 гаруй морь уралдаж давхардсан тоогоор 300 уралдаанч хүүхэд хурдан морь унаж хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг хангаж бүх хүүхэд иж бүрэн өмсгөлтэй, даатгалд бүрэн хамруулж ажиллалаа. Баяр наадмаар ХХАА-н тэргүүний ажилтнаар 2 иргэн Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтнаар 1, яамны жуухаар 2 иргэнийг тус тус шагнасан. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 2019.07.17 нд хуралдаж,

бүсчилсэн хөгжлийн бодлогод санал хүргүүлэх асуудлыг хэлэлцэн А/10 дүгээр тогтоолоор баталж хүргүүлсэн. .

Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах саналын жагсаалт:

- Сумын төвд хатуу хучилттай зам тавих 1,5 тэр бум төгрөг
- Жишиг сум болох / айл өрх, аж ахуйн нэгж төсөвт байгууллагуудын төвлөрсөн халаалт /5,0 тэр бум

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сумын баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд морь барианы газарт засвар үйлчилгээ хийж 600,0 мян төгрөгийн санхүүжилтээр айргийн 5 морины хашааг хийж ашиглалтад оруулсан. Уг ажилд моторын шатахууны зардалд 215,0 мян төгрөг будаг, будаг шингэлэгч 100,0 мян төгрөгийг зарцуулж ажилласан. Мөн Үдэлт угталтын хаалга сэргээн засварлах ажилд тамгын газрын урсгал зардлаас 150,0 мян төгрөг, наадмын талбай будах хойд асрын цемент цутгах зэрэгт 250,0 мян төгрөгийн зардлыг гарган ажилласан.

ОНХС-ын хөрөнгөөр хийгдэх 3 ажлын тендер сонгон шалгаруулалтыг 7/24 нд зохион байгуулахаар цахимаар байршуулсан. Үүнд: баян уул багийн төвийн барилга , цамхаг гэрэлтүүлэг, 04 ЦДАШ засвар шинэчлэлийн ажил зарлагдсан.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын хэмжээнд угаалга, туулгат боловсруулалтад хамрагдсан малын тоо хонь 27000 ямаа 18000 төл 23000 бүгд 68000 толгой мал, туулгатад адуу 2500, хонь 33500, ямаа 16500, бүгд 52500 толгой мал, орон нутгийн вакцинжуулалтад адуу 500, үхэр 2500, хонь 59000, ямаа 31000 нийт 93000 мян толгой мал хамрагдсан.

Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний тусгай захиалгат бүтээгдэхүүний хэрэгжилтийг хангах зорилгоор “50 үнээний сүүний тасаг” -ийг 5-р багийн иргэн Н.Наранбаатартай уулзаж тохирон 35 үнээтэй сүүний тасгийн ажиллагааг 6/15 наас эхлэн ажиллуулсан. Сумын төвийн иргэдэд сүү, тараг, өрөм, чихэртэй чихэргүй ааруулыг Мөнххаан зар зарлал цахим хаягаар хүлээн авч хүргэлтээр хүргэж өрхийн орлогоо нэмэгдүүлэн ажиллаж байна. Өдөрт 70-80л сүүг Түмэн төл аж ахуйн нэгжийн дэлгүүрт нийлүүлж 1000 төгрөгөөр худалдан борлуулж байна. Ааруул 10,0, төгрөг 1000, өрөм 5000 төгрөгөөр худалдан борлуулж байна. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын тайлан зардлын тооцоог гарган холбогдох газарт зураглал тайланг зурагжуулан хүргүүлсэн.

Улсын баяр наадмаар “Цэвэрхэн наадацгаая хандлагаа өөрчилъе” аяныг зохион байгуулж, наадмын 2 өдөр худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа цэг болон наадмын талбай, морь барианы газруудад анонсыг тогтоон хогийн 2 машиныг байршуулан хог хаягдлыг дор бүр нь хариуцсан комисс нар цэвэрлүүлэн хогийн машинуудад ачуулж хогийн цэгт зөөвөрлөсөн. Шатахууны зардал 2 хогийн машинд 30л түлш 72,0 мян төгрөг зарцуулсан. 7-р сарын 5-ны өдөр 2-р багийн засаг дарга Л. Угтахбаяр, 3-р багийн засаг дарга Л. Хүрэлтөмөр, сургуулийн нийгмийн ажилтан Л. Энхээ нар явж сумыг тойрон уяачдад цэвэрхэн наадацгаая санамжийг 312 иргэнд тарааж гарын үсгийн баталгааг авч ажилласан. 7-р сарын 7-ны өдөр Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байцаагч Б. Хүрэлбаатар, Мэнэнгийн сав газрын мэргэжилтэн Болорцэцэг нартай хамт тус сумын төвийн 4-н ундны усны худгаас дээж авч Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт явуулсан. Тус сумын 3-р багийн нутаг болох Мөнххаан ууланд нутагшуулсан тарваганд 2 өдөр мониторинг хийж ажилласан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Зорилтот бүлгийн 5 иргэн бүлгийн зохион байгуулалтад орж ХХҮГ-аас 10 нэр төрлийн 3,5 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмж гардуулан өгсөн. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээн хөгжүүлэх хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт 1 ахмад настан хамрагдаж бүлгийн хүнсний ногооны төсөл дээр зөвлөх үйлчилгээ үзүүлж зөвлөгөө өгөн ажиллаж байна. Малжуулах 3 өрхийн 123 толгой малыг хүлээлгэн өгч 14,0 сая төгрөгийн санхүүжилтээр малжуулсан. Цалинтай ээж 275 иргэнд 13.546.770, жирэмсэн нярай эхийн тэтгэмж 42 иргэнд 1612920, нийгмийн халамжийн тэтгэвэр 95 иргэнд 16.423.370, нийгмийн халамжийн тэтгэмж 70 иргэнд 6.435.100, насны хишиг олголт 188 ахмад настанд 15.610.000 ХЭБ-ийн үйлчилгээ 90 өрхөд 678 эрхийн бичиг 5.424.000 төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

Ерөнхий боловсролын сургуулийн үүдний заалны засварын ажилд нийт 4.571.100 төгрөг шаардлагатай байсныг тус сургуулийн 2004 оны төгсөлтийнхөний хандиваар 2.760.000 төгрөгийг үлдэгдэл 1.811.100 төгрөгийг сургуулийн төсвөөс гарган засварын ажил 80%-тай хийгдэж байна. Сургуулийн 14 анги танхимд нийт 1.400.000 төгрөгний засвар хийгээд байна. ЕБС-ийн сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны урд хэсгийн сул 2 танхимыг эрэгтэй, эмэгтэй технологийн кабинет болгон ашиглахаар засварын ажлыг 820.0 мян төгрөгийн зардлаар тус 2 танхимд бүрэн цутгамал шал хийгээд байна. Аймгийн нийт сумдын технологийн багш нар ирэх сард тус танхимуудын тохижилтын ажлыг хийж гүйцэтгэхээр болоод байна.

Соёлын төв: Номын сангийн олон нийтийн ажил 2 удаа, нийт уншлагад 120 ном гарч 96 хүүхэд, 20 насанд хүрэгчдэд номоор үйлчилсэн. Ном дахин засварлах ажил хийгдэж нийт 120 ширхэг номыг сэргээн засварлалаа. Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Азийн урлагийн Их наадамд аймаг, сум орон нутгаа төлөөлөн Хөгжмийн багш С.Бат-Орших, 11-р ангийн сурагч А.Амингэрэл нар амжилттай оролцож багаараа 6-р байранд шалгарлаа. Сумын баяр наадмаар соёл урлаг үндэстний дархлаа арга хэмжээг хэсэгчлэн зохион байгуулж, нээлтийн арга хэмжээнд нийт 55 хүүхэд, ардын авьяастан төрийн албан хаагчдыг оролцуулан нүүдэлчин монгол ёс заншлыг харуулан зохион байгууллаа. Морьтны гайхамшиг, Хос морьтон, Язгуур урлаг, Морины дуу, Өв тээгчдийг алдаршуулах зэрэг нутгийн өв соёлыг харуулсан тэмцээн уралдаан зохион байгуулагдаж нийт 75 багийн иргэд оролцож 15 иргэнийг 375,000 төгрөгөөр шагнаж урамшууллаа. Сумын баяр наадмаар соёлын өвийн гэр музейг тайлбарлагчийн хамт ажиллуулан гэр музейг 300 гаруй иргэд сонирхсон. Гэр музейд ЗДТГ, 5 багийн иргэд соёлын үнэт өв болсон нийт 120 гаруй үзмэр иргэдийн бүтээл дэлгэгдсэн. Хөшөө цогцолбор сэргээн засварлах ажил хийгдэж нийт 5 хөшөөний будгийг сэргээн будаж, цэцэгжүүлэх талбайг тохижуулан хөшөөний суурийн тэгшлэлтийг хийлээ.

Эрүүл мэндийн төв: 7/23 ны байдлаар 38 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Амбулаторын үзлэг 450 хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 135 иргэн хамрагдсан. Түргэн тусламжийн дуудлага 118 ирснээс алсын дуудлага 16 ирснийг барагдуулж ажилласан.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт, шинэчлэлтийн талаарх хэлэлцүүлгийг суманд зохион байгуулах ажлын хэсэг нь Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөх Р.Жадамбаагаар ахлуулан суманд ажиллаж, 50 иргэдтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэ үеэр 5 иргэн санал хүсэлт тавьж, асуултад хариулт авлаа.

Мөн Монгол улсын үндсэн хуулийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан “Сургагч багш” бэлтгэх онлайн сургалтад сумын Засаг даргын Тамгын газрын дарга аймагт очиж оролцсон. 2019 оны хагас жилийн эрх зүйн ажлын тайланг аймгийн хууль эрх зүйн хэлтэст хүргүүлж ажилласан.

5. Наран сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах саналаа бэлтгэж байна. Сумын Засаг даргын нөөц сангаас 3 сая төгрөг зарцуулан Ардын хувьсгалын 98 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлээ.

07-р сарын байдлаар дээд газраас нийт 23 албан бичиг ирснээс, хариутай бичиг 7 ирж, 3 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 4 албан бичиг байна.

Мөн 07-р сарын байдлаар дээд газраас нийт 4 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын захирамж 3, Аймгийн Засаг даргын албан даалгавар 1 ирж хэрэгжиж байна. 07-р сарын байдлаар иргэдээс сумын Засаг дарга болон Тамгын газрын холбогдох албан тушаалтнуудад хандаж 27 өргөдөл гомдол ирүүлж, хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

2020оны төсвийн төслийг орон нутгийн 4 байгууллага, орлогын төлөвлөлт зэргийг гарган аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн

ЭМТ-ийн барилгын ажил нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа гүйцэтгэл 98%-тай энэ сардаа багтаан хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

ОНХсангаар 2000.000₮ -р хүүхдийн тоглоомын багцыг худалдан авах ажлыг зохион байгуулж гүйцэтгэгчээр Интерворлд ххк шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус сумын 2-р багт ОНХсангаар 3000.000₮-р мал угаалгын банн бариулах ажлын гүйцэтгэгчээр “Сөдөт” ххк шалгарч гэрээ байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлэн гүйцэтгэж байна.

Монгол тарваганы тархац, тоо нутаг, тоо толгойн судалгааг хийх зорилгоор сумын 2-р багийн нутаг болох Бага уулын ар цард ажиллаа. Судалгаагаар нийт 13 дош байсан бөгөөд үүнээс өглөөний гараанаас харахад 5 дошноос 2 нагаа, 2 готол гарч ирсэн. Өглөөний гарааны дараагаас нүх тус бүрт тандалт хийхэд мөндөлтэй байх магадлал өндөр байсан. Улсын баяр наадмыг хоггүй тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас дэвшүүлсэн байгаль орчноо хайрлан хамгаалж хог хаягдалгүй “Цэвэрхэн наадацгаая”, “Хандлагаа өөрчлье” гэсэн уриалга, чиглэлийг орон нутагтаа сурталчилан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаа. Баяр наадмын хурдан морьдын 300 гаруй мандат дээр уриалгыг хэвлүүлэн гаргаж хавсаргаж өгсөн. Сумын нэгдсэн групп болон сошиалаар уг уриалгыг дэмжиж ажиллаа. Аймгийн засаг дарга БОАЖ-ын сайдтай 2019 онд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг үндэслэн Сүхбаатар аймгийн “Наран сумын хог

хаягдлын төвлөрсөн цэгийг цэгцлэх” төслийн хүрээнд 2000.000 төгрөгөөр хогийг цэгийн 4 га, ярганы талбайн 0,5 га газрыг бүрэн цэвэрлэж ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг аймгийн мал эмнэлгийн газартай хамтран дүк машинаар ариутгалж хийсэн ажлын үр дүнгээ БОАЖ Газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэгт хугацаанд нь хүлээлгэн өгсөн.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл,

Эрүүл мэндийн чиглэлээр:

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тус сумын 1-р багийн 1 иргэнд 74 толгой мал, 2-р багийн 3 иргэнд 165 толгой мал өгч малжуулах ажлыг зохион байгууллаа.

Тэтгэвэр тэтгэмжийн олголт: 06 дугаар сарын 30-ны байдлаар

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	135	22445970
2	Байнгын асаргаатай ахмад ,хүүхэд ХБИргэдийг асардаг	227	15155820
3	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд	86	9774030
4	Ахмад настны тухай хуулийн дагуу	66	5810000
5	ХБ хүний эрхийн тухай хуулийн дагуу	55	1534330
6	Жирэмсэн эхийн тэтгэмж	106	3463180
7	Алдарт эхийн одонтой эхэд	126	17000000
8	Хүүхэд асарсны тэтгэмжинд	498	24177320

Сумын ЭМТ -ийн Үндсэн үзүүлэлтүүд:

Нийт үзлэг-346

- Урьдчилан сэргийлэх-104
- Амбулаторийн үзлэг-126
- Идэвхитэй хяналт-91
- Хэвтэн эмчлүүлсэн-9
- Артерын гипертензи, чихрийн шижингийн эрт илрүүлэг-31
- Хяналтанд байгаа жирэмсэн-21 шинээр -2
- Хөхний үзлэг-116
- Эсийн шинжилгээнд-15
- Сувилахуйн тусламж үйлчилгээний хүрээнд Нийт тариа хийлгэсэн хүний тоо-207, дусал тариа-112, судас тариа-257, булчин тариа-30 хүнд

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт, шинэчлэлтийн талаарх хэлэлцүүлгийг суманд зохион байгуулах ажлын хэсэг нь Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөх Р.Жадамбаагаар ахлуулан суманд ажиллахад 53 иргэдтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэ үеэр 3 иргэн санал хүсэлт тавьж, асуултад хариулт авлаа.

Мөн Монгол улсын үндсэн хуулийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан “Сургагч багш” бэлтгэх онлайн сургалтад сумын Засаг даргын Тамгын газрын дарга аймагт очиж оролцсон.

Энэ сард баяр болсонтой холбогдуулан хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар худалдаа үйлчилгээ эрхлэгч 8ААН-д мэдээлэл өгч хяналт шалгалтыг зохион байгуулсан.

Хагас жилийн хууль эрх зүйн бичмэл тайлан болон мэдээгээ хугацаанд ХЭЗХ-т хүргүүлсэн байна.

6. Онгон сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Жишиг байр төсөл хэрэгжүүлж сумын төвийн Дэнжийн байрыг засварлах ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.

2-р багийн өдөрлөгийн арга хэмжээг ЗДТГазраас зохион байгуулж урлагийн тоглолт бэлтгэн малчин иргэдэд сонирхууллаа. Уг арга хэмжээний үеэр Нийгмийн даатгал, Халамж, Газрын асуудал хариуцсан мэргэжилтнүүд иргэдэд мэдээлэл өгч санал хүсэлтийг хүлээн авлаа.

Ардын хувьсгалын ойн баяр наадмаар 12 иргэнд аймгийн Засаг дарга, ИТХ-ын шагналаар шагнасан.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Монгол Улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг хэрэгцээт үед нь тогтмол гарган өгч байна.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй болон ажиллаа.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгч байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын төвийн ногооны талбайд Кожеговь ХХК-ны хөрөнгө оруулалтаар гүн өрмийн худаг гаргасан бөгөөд ус нөөцлөх сав, намирааг худалдан авч байрлуулаад ажиллуулж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг сард 1 удаа хуралдуулж 5 иргэний материалыг Нийгмийн халамжийн хэлтэст хүргүүлэн ажиллаа.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Усархаг бороо их орж байгаатай холбогдуулан малчид, ард иргэдэд үер усны аюулаас хамгаалах чиглэлээр Дата мессежээр мэдээлэл хүргэлээ.

7. Түвшинширээ сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Сумын баяр наадмыг 07 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгууллаа. Баяр наадмын хөтөлбөрийн дагуу 6 насны 296 морь уралдаж, үндэсний бөхийн

барилдаанаар 32 бөх барилдан, 1 сумын заан цолтон төрөн гарсан байна. Хурдан морины уралдааны үеэр уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган даатгал, хамгаалалтын иж бүрэн хувцастай уралдааны замд гаргах ажлыг морины комисс зохион байгуулан ажилласан.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сар бүрийн 8 ны дотор шилэн дансанд байгууллагуудынхаа сарын төсөв гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл бусад мэдээ мэдээллийг шивж байна.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 \ ажиллагсдын цалин тооцооны хуудас\ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг сар бүр гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн.

Тогтмол хийж гүйцэтгэж буй ажил:

- Сар бүрийн санхүүжилт ЗЭБ маягтын дагуу тавих
- Байгууллагуудын гүйлгээг хийх
- Цалин хөлс бодох
- Цалинтай холбоотой тооцоо гүйлгээнүүдийг хийх
- Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэх
- НДД ЭМД бичилт хийх
- Мэдээ тайлан гаргах
- Бичиг баримт, меморалаа цэгцлэн үдэх

· Байгууллагуудаас ирж буй гүйлгээнүүдийг тухай бүр Freebalance програмд шивэн албаны даргаар баталгаажуулан ажиллаж байна.

§ Орон нутгийн ерөнхий орлого, татварын орлогын гүйцэтгэлийн мэдээг шилэн дансанд шивсэн.

§ Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 3-ны дотор гарган ажиллаж байна.

§ Э-тайланд төсөвт байгууллагуудын хагас жилийн санхүүгийн тайланг шивж оруулсан.

§ Төсөвт байгууллагуудын 2019 оны төсвийн төсөл, 2020 – 2021 оны төсвийн төсөөллийг хийж хариуцсан мэргэжилтэн тушааж програмд шивж илгээсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

07 дугаар сарын 4-ны өдөр зөрчил шалган шийдвэрлэх ажлын үнэт цаасны тайланг Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтыг газарт хүргүүллээ. Мөн 07 дугаар сарын 8-ны өдөр Дэлгэрхаан багт ажиллаж буй Монгол-Америкийн хамтарсан археологийн судалгааны багт багийн Засаг дарга Д. Амар, сумын хэсгийн төлөөлөгч Ууганбаяр, БОХУБайцаагч Г.Одончимэг нар хамтарч хяналт хийж ажилласан. Хяналт шалгалтаар малтлагын үед Дэлгэрхаан уул, Булгийн гол орчимд хийж байгаа ба шавар ваар, хүрэл тогоо зэрэг олдвор олдсон ба олдворыг цахим орчинд газар, уулын нэртэй зөвшөөрөлгүй оруулсанд тайлбар авлаа. 07 дугаар сарын 20-ны өдөр байгаль хамгаалагч А. Энххүрэл, БОХУБайцаагч Г. Одончимэг нар Өлзийт багийн нутаг Тангад, Бүрзээхэй нутгуудаар хяналт шалгалт хийж байгалийн өнгөт чулуу хууль бусаар олборлож буй нэг иргэний зөрчлийг илрүүлсэн. Тус иргэнд зөрчлийн тухай хуулийн 7.11 зүйлийн 7.1-т заасны дагуу арга хэмжээ авч ажиллалаа.

Геодезийн цэг тэмдэгтийн жагсаалт, хувийн хэрэг, GPS зэргийг ашиглан 2018 онд тоологдоогүй 14 цэг тэмдэгтийн тооллогын ажлыг багийн Засаг дарга нартай хамтран зохион байгууллаа.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 1 удаагийн татан авалтаар ОХУ-д үйлдвэрлэсэн 080419 серийн дугаартай 300 л вакциныг Аймгийн Мал эмнэлгийн газраас татан авч ажлын 5 хэсэгт хуваарилан өгч мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа. Сумын хэмжээнд 298370 толгой мал вакцинжуулалтад хамрагдахаас 5 багийн 410 хот айлын үхэр 13061, хонь 152792, ямаа 109742, бүгд 275595 толгой мал хамрагдсан байна. Тарилгад 288,656 л вакцин зарцуулж, хэвийн хорогдолд 1,344 л-ийг устгаж, үлдэгдэл 10 л вакциныг аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн. Мөн шөвөг яр, сахуугийн вакцин төл малд хийгдсэн. Одоогийн байдлаар 20000 төл малд шөвөг ярын вакцин хийгдсэн байна. Орон нутгийн дотрын халдварт хордлого, галзуугийн вакциныг татан авч хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдэд хуваарилан өгч тарилгын ажлыг эхлүүлээд байна.

Мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээнд баталгаажуулалт хийж байна.

Төл бойжилт, зүй бус хорогдлын мэдээг багийн дарга нараас авч нэгтгэж, статистикийн газарт хүргүүлсэн. Оготоно устгалын тайланг аймгаас ирүүлсэн 12 заалтын дагуу бүрдүүлж явуулсан.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит 11 дүгээр хурлын 06 тоот тогтоолыг үндэслэн Өлзийт багийн нутаг Халзан уул орчмын отрын бүс 20000га, Өгөөмөр багийн Хөндий орчмын 15000 га, Баруун ухаа, Ганганы бууц, Бүрзээхэй, Далан түрүү, Тээг, Шүүт, Талын бууцны худаг, Баруун салаа орчмын - га бэлчээр нутгийг 07 дугаар сарын 18- ний өдрөөс 10 дугаар сарын 01-ыг хүртлэх хугацаанд чөлөөлөх захирамж төлөвлөн бэлчээр чөлөөлөх тухай сумын Засаг даргын А/64 захирамжийг батлуулж захирамжийг тухайн бэлчээр чөлөөлөх Багийн Засаг дарга нар болон малчид, Бэлчээр ашиглалтын малчдын бүлгийн ахлагчид танилцууллаа. Мөн сумын хэмжээнд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж, тариалалт хийсэн өрхүүдээр явж мэдээлэл аван өрх бүрээр ХАА-7 маягтаар шивж оруулсан.

Одоогийн байдлаар 50 үнээний ферм байгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д "Ажилд орсон иргэн"-ийг түр ажлын байрын зуучлалд- 11 иргэн, шинэ ажлын байр-2 мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэсэн.

Сумын хэмжээнд 2017 онд малжуулах хөтөлбөрт хамрагдсан 5 өрхөөс 2 өрх эргэн төлөлтөө хугацаанаас өмнө төлж барагдуулсан, одоогоор 3 өрхийн 550,0 төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба хуваарийн дагуу 7-р сард 3 өрхийн 200,0 төгрөг хийсэн, сүүлийн төлөлт 8-р сард 550,0 хийж дуусахаар байна. 2018 оны малжуулах хөтөлбөрт хамрагдсан 4 өрхөөс 7 сард хийх хуваарийн дагуу 200,000 төгрөг, "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-т хамрагдсан 1 иргэн 50,000 төгрөг, Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 4 иргэний 400,000 төг, 2017-2018 онд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 2 иргэн 170,000 төгрөг, "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хөтөлбөрт 1 иргэн-50,000 төгрөг нийт 15 иргэн 1,070,000 төгрөгийн ХЭДС-ийн дансанд бүрэн төвлөрүүллээ. "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хөтөлбөр"-т сумын ЗДТГ-аас ахмад мэргэжилтэн Д.Үржингармааг ажиллуулах санал төсөл боловсрууллаа. "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн гэрээт малчин өрхийн хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд мал маллах сонирхолтой аймаг, сум, төвлөрсөн төв суурин газарт амьдарч буй өмнө нь мал маллаж байсан болон шинээр мал маллах сонирхолтой 18-59 насны хөдөлмөрийн чадвартай 2-оос доошгүй гишүүнтэй өрх, мөн бог малд шилжүүлсэнээр 600 болон түүнээс дээш тооны малтай гэрээт малчин авч ажиллуулах сонирхолтой малчин 2 өрхийг бүртгэсэн.

7-р сарын байдлаар Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдсан 6 иргэнд 1,001,580 төгрөгийн мэдээллийг жагсаалтаар гаргасан. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдаагүй, шинээр төрсөн хүүхэдтэй холбоотой 2 өрхийн өргөдлийн дагуу судалгааг авсан. Хагас жилийн байдлаар сумын "Хөгжлийн бэрхшээлтэй иргэн", "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд" "Хараагүй хүүхдийн судалгаа"-г маягтын дагуу авч, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн-85 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд-17, харааны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхээс-1 судалгаануудыг авсан байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралт сувилалд 3 ахмад амарч сувилуулсан. Ахмад настны хуулийн дагуу 1 ахмад настанд шүдний хөнгөлтийн хувийн хэргийг WAIS программд бүртгэн нээж аймгийн ХХҮГ-ын даргаар баталгаажуулахаар хүргүүлсэн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй 2 өрхийн 3 иргэний хөдөлгөөнийг мэдээгээр баталгаажуулан хүргүүллээ. Эрхийн бичгийн үйлчилгээнд шинээр хамрагдах эрх үүссэн 1 өрхийн хувийн хэргийг бүрдүүлэн хүргүүллээ.

Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж уг хурлаар нийт 4 өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд: Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч буй 4 иргэний өргөдлийг хэлэлцэн тэтгэмж шинээр тогтоох, мөн дахин сунгалт зэргийг 4 иргэнд тогтоосон хурлын шийдвэрийг тэмдэглэн хувийн хэргийн баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлсэн.

Цалинтай ээж хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарч буй эхэд олгох шинээр тэтгэмжид хамрагдах 10 иргэнд хувийн хэрэг нээн 329030 төгрөгийн тэтгэмжид хамруулсан.

Улсын баяр наадмыг тохиолдуулан ахмад настанд насны хишиг олгох тэтгэмжид шинээр хамрагдах 2 ахмад настанд хувийн хэрэг нээж, 70 нас хүрсэн 3 ахмад насны насны шилжилтийг WAIS программд бүртгэсэн. Энэ жилийн наадмын хишигт сумын хэмжээнд 65-69 насны 46 ахмад-2300,0 төг, 70-79 насны 53 ахмад-

4240,0 төг, 80-89 насны 17 ахмад-2550,0 төг, 90-ээс дээш 2 ахмад-500,0 нийт 118 ахмад 9590,0 төгрөгийн бүрэн тэтгэмжид хамруулсан.

Жирэмсэн эхийн тэтгэмжид 8 иргэнд 374200 төгрөг нийт иргэдийн хувийн хэргийг нээж батлуулан WAIS программд бүртгэн иргэдийг цаг тухай бүрд тэтгэмжид хамруулсан. Мөн 7-р сарын тулгалтыг хийж 8 иргэний 243240 төгрөгийг таталт хийлгэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу Нийгмийн халамжийн тэтгэвэрт шинээр 1 иргэнд, тэтгэвэр авагч иргэн хугацаа дуусч сунгалт хийгдсэн 4 иргэн, мэдээллийг программд шивж батлуулан 917390 төгрөгийг нэмэлт жагсаалтаар өгч иргэдийн тэтгэврийг үргэлжлүүлэн олгосон.

Энэ сарын ЭМД-д 14 хүний 962,4 төгрөг орж төлөвлөгөө 93,9%, СДД-д 22 хүний 1398,0 төгрөг орж төлөвлөгөө 77,5% биелж, 7 сарын тэтгэвэрт 2 банкаар 377 хүнд 117295,1 сая төгрөгний тэтгэвэр, 1 хүнд оршуулгын тэтгэмж олгон, шинээр 2 хүний тэтгэврийг тогтоогоод НДХ хүргүүлээд байна.

Соёлын төвийн хөгжим, бүжгийн багш нар нь сум үүсэн байгуулагдсаны 94-н жилийн ойн баяр наадмын арга хэмжээг угтан, соёлын төвийн дэргэдэх хөгжим бүжгийн дугуйлангийн сурагчдын “Янзган хүрээ” хамтлагийн “Мөрөөдлийн зүг” тайлан тоглолтыг 07.05-ны өдөр сумын иргэд, хүүхэд багачууд, наадамчин олонд өргөн барилаа. Тоглолтонд нийт 10 хүүхэд оролцож 90 гаруй хүн үзэж сонирхсон байна. Ардын хувьсгалын 98-н жил сум үүсэн байгуулагдсаны түүхт 94-н жилийн ойн баяр наадмын нээлтийн арга хэмжээ, хүндэтгэлийн тоглолт, үдшийн цэнгүүн болон бусад соёл урлагийн арга хэмжээг сумын ардын авьяастанууд, хөгжим бүжгийн дугуйлангийн сурагчидтай хамтран зохион явууллаа. Уг арга хэмжээг нийт 24 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж арга хэмжээнд оролцсон ардын авьяастнууд болон дугуйлангийн хүүхдүүдээ урамшуулж ажилласан байна.

Сумын Эрүүл мэндийн төв 7 дугаар сард алсын дуудлагаар 12 удаа, гэрийн дуудлагаар 28 удаа үйлчилсэн байна. Үүнээс 4 хүнийг аймгийн нэгдсэн эмнэлэгт хүргэж өгсөн байна. Мөн дархлаажуулалтад 51 хүүхэд хамруулж, амбулаторын үзлэг 326 хүнд хийж, ЭМТ-д 25 хүн хэвтэн эмчлүүлж, өдрөөр 28 хүнд стори нээж, сэргээн засах эмчилгээнд 23, артерийн даралт, чихрийн шижин өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт 23, хөх, умайн хүзүүний хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт 23 хүн хамруулаад байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

07 дугаар сарын 16-нд аймгийн ЗДТГ-т үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан зохион байгуулж байгаа сургагч багш бэлтгэх онлайн сургалтад сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Бат-Эрдэнэ, НЗЭЗБХМ-ний ажил үүргийг хавсран гүйцэтгэгч Ш.Дүүрэнбилэг нар оролцлоо. Сумын ЗДТГ-ын ХАА-н мэргэжилтэн У.Эрдэнэцэцэг хуц, ухныг хээлтэгч малаас тусад нь байлгах талаар шинээр хэрэгжиж байгаа генетик нөөцийн хуулинд заагдсаныг энэ сард 5 малчинд танилцуулсан.

8. Түмэнцогт сумын сарын ажлын мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Сумын Засаг даргын 2019 оны 06 сарын 19 өдрийн А\50 тоот захирамжаар Ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах хороо, салбар хорооны бүрэлдэхүүнийг 64 хүний бүрэлдэхүүнтэй томилон баяр наадмыг зохион байгуулж ажиллалаа. Баяр наадмын нээлт, жагсаалд 11 байгууллагын 120 гаруй албан хаагч жагсаж, хүндэтгэлийн тоглолтод 30 гаруй ардын авьяастан оролцлоо. Мөн “ДЭЭЛТЭЙ МОНГОЛ” үндэсний дээл хувцсаараа дэгжирхэн гоёх уралдаанд 80 гаруй иргэн оролцож Сайхан монгол дээлтэй хос, Сайхан монгол дээлтэй гэр бүл, Сайхан монгол иж бүрэн тоноглол бүхий Талын сайхан эрэгтэй, Сайхан монгол дээлтэй Талын сайхан эмэгтэйг тус тус шалгарууллаа. Нүүдлийн соёлын өвийг өвлөн уламжлагч малчин гэр бүлийг алдаршуулах, уламжлалт ёс заншлаа сурталчлах арга хэмжээ сумын баяр наадмын өнгийг нэмж монгол морины гайхамшгийг харуулах, монгол үндэсний эд өлгийн соёл, дээл хувцсаараа бахархах зорилгоор ХОС МОРЬТОН тэмцээнийг зохион явуулж 8 гэр бүл оролцож эхний 3 байрыг шалгаруулж Засаг даргын нэрэмжит шагналаар тус тус шагнаж урамшуулсан. Он цагийн хэлхээ хүндэтгэлийн тоглолт тавигдаж 100 гаруй иргэнд баярын мэндчилгээ хүргэн тоглолтоо толилуулсан байна. Баяр наадмын хаалтын арга хэмжээ буюу “Хийморьлог наадам” үдшийн шоу арга хэмжээг зохион байгуулж нийт 152 хүн хамрагдаж 22 азтан тодруулсан. Баяр наадмаар сумын Начин цолтон шинээр 1 төрж, Сурын харвааны төрлөөс Сумын Мэргэн цолны болзлыг 2 харваач хангаж Цол тэмдгээ гардан авсан. Наадмын талбай болон автомашины зогсоолын өнгө үзэмжийг сэргээн будаж, засварлах ажилд Засаг даргын нөөц сангаас 320.000₮ зарцуулсан.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Шилэн дансны тухай хуулийн 5-р зүйлийн 5,3 дах заалтыг хэрэгжүүлэх үүднээс 7-р сарын мэдээг шилэн дансны вейб сайтад байршуулан Сангийн яам болон холбогдох хэлтэс агентлагт хувиарийн дагуу мэдээг хүргүүлэн ажилласан. Төсөвт байгууллагуудын санхүүгийн дэмжлэгийг хувиарын дагуу санхүүжүүлэн ажилласан. Санхүүгийн хагас жилийн санхүүгийн тайланг хүргүүлж, 2020 оны төсөвт байгууллагын төсөв 2021-2022 оны төсвийн төсөөллийг нэгтгэн хүргүүллээ. Орон нутгийн орлогын биелэлт: /7 сар өссөн дүнгээр мян.төг /

• Үйл ажиллагааны орлого	1881.6
• Шууд бус орлого	2099.6
• Хөрөнгө борлуулсаны орлого	14500.3
• Буу	56,0
• Улсын тэмдэгтийн хураамж	953,9
• Хүү торгуулийн орлого	7039,9
• ТТАМ	52,5
• Бусад нэр заагдаагүй орлого	65000,0
• Дүн	91583,8

Статистикийн хэлтэст сарын мэдээг хуулийн хугацаанд дамжуулан ажиллахаас гадна улиралын мэдээ болох МЭ-1, ХУ –ийн мэдээнүүдийг дамжуулан ажилласан

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын хэмжээнд Гоц халдварт болон халдварт өвчин гараагүй тайван байна. Одоогоор төл болон том малын хорогдол гараагүй хэвийн байна. Сумын Засаг даргын 2019-07-05 өдрийн А\58 дугаар захирамжийн дагуу халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал халдваргүйжүүлэлт тарилга, туулгалт, угаалга хийгдэж байна. МЭ-06-маягтаар мал эмнэлэгийн мэдээг төлөвлөгөөт хугацаанд хүргүүлж, мал амьтны гарал үүсэл шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ХХМЭНэгжүүдээс авсан ариун цэврийн гарал үүслийн шинжилгээний бичигтэй тулган бүртгэл хийн ажиллаж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Энэ сард хөтөлбөрт үдэшлэг цэнгүүнийг 2 удаа зохион явуулж нийт 190 иргэд хамрагдлаа. Мөн иргэдийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор Зумба бүжгийн хичээлийг тогтмолжуулан хичээллэж байна. Соёлын төвийн дэргэдэх

бүжгийн дугуйланг хичээллүүлэн, тогтмолжуулан бага бүлэг, ахлах бүлэг гэсэн 2 насны ангиллаар монгол ардын бүжгийн дасгал хөдөлгөөнийг зааж байгаа ба дугуйланд бага бүлэгт 30, ахлах бүлэгт 20 сурагчид хамрагдаж байна. Сумын орон нутгийн музейг насанд хүрэгчид 20, хүүхэд 5 үзэж сонирхон танилцсан байна. Мөн орон нутаг судлах музейн дотоод болон гадаах засвар үйлчилгээг хийж гүйцэтгэлээ. Аймгийн Угсаатны зүйн музейд сумын тахилгат овооны судалгааг нэгтгэж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн болно.

Энэ сард номын сангаар 12 хүүхэд, 15 насанд хүрэгч уншигчдад 32ш номоор үйлчилсэн байна. Хагас жилийн номын тооллого, бүртгэлийг хийж номын сангийн цахим үйлчилгээгээр иргэдэд үйлчилж байна.

Хүүхэд багачуудын зуны амралтыг тохиолдуулан тэднийг хөгжүүлэх, зураг зурах сонирхлыг нэмэгдүүлэх, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор "Уран зургийн дугуйлан"-г Түмэнцогт сумын Соёлын төв, Анима ДУДС-ийн оюутан Л.Минжинсор нар хамтран зохион байгууллаа. Уг сургалтад 13 сурагч хамрагдаж, суралцсан хугацааны бүтээлүүдээр үзэсгэлэн зохион байгуулж, эцэг эх, үеийн найзууддаа тайлагналаа. Мөн сурагчдын сургалтын төлбөрийн 50 хувийг зорилтот бүлгийн өрхөд хандивлалаа.

Эрүүл мэндийн төвийн амбулаториор 412 иргэн үзлэг хийлгэн, лабораторид-51, сэргээн засах эмчилгээнд-8, яаралтай тусламж үйлчилгээнд- 10 хүн хамрагдаж, түргэн тусламжийн алсын дуудлага-18, ойрын дуудлага-90, гэрийн идэвхтэй эргэлтээр 7 эх, нярайд давтамжтай тоогоор 28 удаа эргэлт хийж үйлчилсэн байна. 0 - 5 насны хүүхдүүдийг товлотт вакцинд 38/38 бүрэн хамруулж, умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд 14 иргэн, Хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт 44 иргэн , Артерийн гипертензи , чихрийн шижингийн эрт илрүүлэгт 194 - иргэн хамруулаа. ЭМТ-ийн үйл ажиллагаа болон, НЭМ-ийн үндэсний хөтөлбөрүүдийн хагас жилийн тайланг нэгтгэж хүргүүллээ.

Түмэнцогт ОБГ-ын 12 албан хаагч, сумын төлөөлөгч, цагдааг хамруулан 14 хүнд "Тарваган тахал"-ын вакцинд хамруулсан.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Эрх зүйн ажлын хагас жилийн мэдээг нэгтгэн аймгийн хууль зүйн хэлтэст хүргүүлсэн.

Боржигон овогт Жамъяандагвийн үр хүүхдүүд, ач зээ нарын “ҮРИЙН ҮРД ҮРГЭЛЖЛЭХ ҮҮРДИЙН ХОЛБОО” ургийн баярт урилгаар очиж угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтыг зохион байгуулж 160 гаруй иргэнд гарын авлага материал өгсөн.

Шийдвэрийн хяналтын дагалдах хуудас боловсруулалтад хяналт тавьж 5-н шийдвэр гаргах түвшинд гарын үсэг зурж 3-ийг буцаан боловсруулахаар өгсөн байна.

Хуулийн нэгдсэн сайт болон эрх зүйн гар сангаас хуулийн зөвлөгөө давхардсан тоогоор 64 албан хаагч, иргэнд хүргэсэн.

Төрийн албан хаагчдын хувийн хэргийг Төрийн албаны шинэ хууль болон холбогдох тогтоолын дагуу шинэчлэн бүрдүүлж баяжуулан зориулалтын сейфэнд хадгалж төрийн албаны стандартыг хангаж байна. ЗДТГ-ын бичиг хэргийн зардлаас 185.000₮ зарцуулж зориулалтын сейф, хавтсыг худалдан авлаа.

9. Халзан сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

АИТХ-аас хавдар сувиллын үндэсний төвтэй хамтран элэгний В вирустэй сумын иргэдийн судалгааг гарган нэг сар уух вирусны эмийг 10 иргэнд үнэ төлбөргүй олгосон.

Үндэсний их баяр наадмын өдрүүдтэй холбогдуулан иргэдийн амь нас, аваар ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ГХУСАЗЗ-өөс хэсгийн төлөөлөгч цагдаатай хамтран “ЯАРААД ЯАХАВ ДЭЭ” аяны хүрээнд машин мотоцикл хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслүүдэд анхааруулга санамж бичиг тараах материал өгч ажиллалаа.

2019 оны хагас жилийн санхүүгийн тайлан болон 2020 оны төсвийн төслийг холбогдох газар нь хүргүүлээ.

б. Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

ТГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын ажилтан албан хаагчдын хүчээр жил бүр нэг бүтээлч ажлыг санаачлагаараа хийж байхаар тусгасны дагуу “**Баяр наадмын талбай**”-г будах, шохойдох, засварлах мөн түүнчлэн хогийг нь цэвэрлэх, шуурсан элсийг зайлуулах гэх мэт 10,0 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг сумын ИТХ, ТГ-ын ажилтан албан хаагчдын хүчээр хийж гүйцэтгэлээ.

МУ-ын засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоолоор энэ оныг “**Эх оронч худалдан авалтын жил**” болсонтой холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны

06 дугаар сарын 21 ны өдрийн 02 тоот албан даалгаврын биелэлтийг 13 үзүүлэлтээр ханган ажиллахыг үйлдвэр эрхлэгчид сурталчлан таниулж биелэлтийн тайлан, тоо хэмжээг улирал бүр нэгтгэн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

07 дугаар сарын эхний 10 хоногт **“Халзан-вэб сайт”** ашиглалтад оруулж холбогдох мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулж байна.

Тухайн оны 09-р сард архив бичиг хэргийн улсын үзлэг ирэхтэй холбогдуулан хийх ажлын төлөвлөгөөнд бичиг баримтыг цахим бүртгэлд оруулахаар тусгасан юм. Үүний үр дүнд 07-р сарын 18 ны өдөр ГРАНД МАКС ХХК-ны захиралтай ТГ-ын дарга гэрээ байгуулж албан тоотоор хүсэлт хүргүүлэн 1400000 төгрөгийн өртөг бүхий **“Авто сканнер”** захиалаад байна.

Аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын 2019 оны 06 дугаар сарын 25 ны өдрийн 9/866 тоотын дагуу **“Төрийн удирдлага”** онол арга зүйн сэтгүүлийг 3 дугаар улирлаас эхлэн захиалж Нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчид, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг сурталчлан таниулж байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Энэ сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 24600,0 мянган төгрөг, сумын татварын орлогоор 499,7 мянган төгрөг бүгд 25099,7 мянган төгрөг орж, орон нутгийн байгууллагуудын санхүүгийн дэмжлэгээр ИТХ 4282,3, ЗДТГ 24334,3 мянган төгрөг олгосон. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын хувьд: ЕБС 11984,9, ЭМТ 28406,9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Зарим байгууллагын санхүүжилт ирээгүй, төсөвт албан байгууллагуудын зардлын гүйлгээ гаргахад бэлэн болоод байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

2019 оны 07 дугаар сарын 22-ны байдлаар шинээр 4 зээлдэгчид нийт 26000000 сая төгрөгний зээл олгоод байна.

2019 оны 07-р сарын 22-ны байдлаар нийт 20 зээлдэгч байгаагаас 2019 оны 07 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 6 хүнээс 1.142.153 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн.

Төмс, хүнсний ногооны тариалалт эрхэлж байгаа албан байгууллага, иргэдийн судалгаа, тариалалтын мэдээгээр албан байгууллага-3, айл өрх-12 нийт 1 га /төмс, хүнсний ногоо/ тариалаад байна.

7-р сарын 4 ны өдөр Сумын төвийн 4-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн хашаа хороо, саравч, агуулах, зоорь зэрэгт орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ зохион байгуулах тухай А/55 захирамжийн дагуу нийт 12 иргэний малын хашаа хороо, өтөг бууц, 2 агуулах, зоорийг нийт 6000 м² талбайд халдваргүйжүүлэлт хийлээ.

7-р сарын 5 ны өдөр Улаанбаатар хотын Мал Эмнэлгийн Ерөнхий газрын мэргэжилтэн Батцэнгэл “МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР”-ын хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах журмаар ажиллаа. Мөн аймгийн Мал Эмнэлгийн Зооноз, халдварт өвчин, тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Идэрбат шүлхийн 2-р ээлжний вакцины хуваарилалт, гүйцэтгэлтэй танилцаж зөвлөгөө мэдээлэл өгсөн.

7 дугаар сарын 6,7 ны өдөр Халзан сум байгуулагдсаны 94 жилийн ойн баяр наадамд Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж, морины комиссын гишүүнээр шинэ залуу малын эмч нар ажиллаа.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Хүүхдийн цэцэрлэг: Хашаанд тарьж байгаа хүлэмжийн ногоо, модыг усалж тордож, зэрлэгийг түүж арчиллаа.

Эрхлэгч няботой ирэх оны төсвийн төслөө хийж гүйцэтгэлээ.

100 хүүхдийн шинэ цэцэрлэгийн барилгын ажил эхэлсэн.

Соёлын төв: Улсын баяр наадмын нээлтийг морин хуур уртын дуугаар эхлүүлж баяр наадмын үйл ажиллагаанд зориулан тоглолт хийн наадамчин олон түмэнд үйлчиллээ. Мөн Сайхан морьтон, Монголоороо гоёцгооо, Шагайн харваа зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж нийт 58 хүн хамрагдаж 250 хүнд үйлчилсэн

Халамж: Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн шугамаар ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан Г.Ганбаатар суран эдлэл төсөл хэрэгжүүлэхээр 5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авлаа. Халзан дулаан ОНӨУ газарт зорилтот бүлгийн 5 иргэн түр ажлын байраар зуучлагдан ажиллаж байна. Хөдөлмөрийн мэдээллийн санд ажил хайгч 1 иргэн, шинэ ажлын байр 1 иргэн, ажил зуучлалд 1 иргэн бүртгэгдлээ. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээгээр ахмад настан иргэн Г.Жаргал өрхийн хоол үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлэн 1500000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдан үйл ажиллагаагаа эрхэлж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн шугамаар бүлгээр хүнсний ногоо тариалалт ургацийн ургалт хэвийн байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Нийгмийн халамжийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ахмадуудад “Ахмад настны нийгмийн хамгааллын хууль” сургалтыг зохион байгуулан тусгай хэрэгсэл болон аймгийн ХХҮГазрын дэргэдэх ахмадын амралт сувиллын талаар 15 иргэнд мэдээлэл өглөө. Байнгын асаргааны мөнгөн тэтгэмжид хамрагддаг байнгын асаргаатай иргэдийг асардаг иргэдэд “Хэвтрийн өвчтөнийг асархуй” сургалтыг Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулан 20 иргэнд сургалт зохион байгууллаа. Шинэ төрсөн 1 хүүхдийн бүртгэлийг газарт хүргүүлэн мэдээллийн санд оруулсан.

Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд : Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй эхнэрээ олон жил асарч тойлж байгааг үнэлэн зорилтот бүлгийн, заавал хөгжих өрхийн иргэн Х.Ганбаатарыг Засаг дарга 100000 төгрөгөөр шагнаж урамшууллаа. Аймагт ХГБХГазраас зохион байгуулсан эмэгтэйчүүдийн “Гэр бүлийн харилцаанд эмэгтэйчүүдийн оролцоо” зөвлөгөөнд зорилтот бүлгийн заавал хөгжих өрхийн иргэн Б.Наранцэцэг, М.Бадрахцэцэг нарыг төлөөлөгчөөр оролцууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжийн олголт:

№№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг
1	Халамжийн тэтгэвэр	29	5104000
2	Байнгын асаргаа ХБИ тэтгэмж	9	540000
3	Байнгын асаргаа ХБИ асрагч тэтгэмж	9	666000
4	Байнгын асаргаа ахмад тэтгэмж	17	1020000
5	Байнгын асаргаа ахмад асрагч тэтгэмж	17	1258000
6	Жирэмсэн амаржсаны тэтгэмж	13	520000
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэвэр	3	528000
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрагч	3	222000

9	Цалинтай ээж хөтөлбөр	87	4350000
10	Хэл яриа, харааны бэрхшээлтэй иргэний харилцаа холбооны зардал	6	120000

10. Уулбаян сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Долдугаар сард 202 албан бичиг бүртгэгдэж үүнээс хугацаатай 64 албан бичгийг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэн тусламж хүссэн /гэр/ -2, /малжуулах/-10, ажил хүссэн -4, бусад 2 нийт 18 иргэний өргөдлийг бүртгэлд авч шийдвэрлэсэн.

7 сарын байдлаар төрөлт 29, нас баралт 17, гэрлэлт 1, иргэний үнэмлэх сунгалт 43, шинээр олгосон 11, шилжин ирсэн 28 бүртгэгдсэн байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

7 сарын байдлаар орон нутгийн орлого төлөвлөгөөгөөр 22733.7 мянган төгрөг орохоос 78547.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөө 345.5 хувийн биелэлттэй.

Орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл:/ 6 сарын мэдээ /

Орлогын нэр төрөл	2018 онд батлагдсан төсөв	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт орлого	61540.0	22733.7	78547.6
Татварын орлого	42540.0	12233.7	11715.1
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	15000.0	9333.7	9521.3
үйл ажиллагааны орлого	1200.0	600.0	40

Бууны албан татвар	1140.0	0.0	60
Улсын тэмдэгтийн хураамж	2000.0	900.0	1043.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1000.0	500.0	600
Ан агнуур ашигласны төлбөр	20000.0	0.0	
Ус ашигласны төлбөр	1200.0	600.0	450
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1000.0	300.0	
Татварын бус орлого	19000.0	10500.0	66832.5
Хүү торгуулийн орлого	9000	4500.0	7660.3
Нэр заагдаагүй бусад орлого		0.0	50000
төсөвт газрын өөрийн орлого		0.0	
Хөрөнгийн орлого	10000.0	6000.0	9172.2
Хөрөнгө борлуулсны орлого	10000.0	6000.0	9172.2
Оны эхний үлдэгдэл	0.0	0.0	

1-6 сарын санхүүгийн дэмжлэг 162200.0 мянган төгрөг ирэхээс 162200.0 мянган төгрөг ирж 100 хувийн гүйцэтгэлтэй.

Эхний 6 сарын байдлаар төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээллийг бүрэн оруулж, хагас жилийн санхүүгийн тайлан, 2020 оны төсвийн төслийг хугацаанд нь хүргүүлсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Уурхайтай хамтран ажиллах гэрээний дагуу Сун хун гоулд, Шинэ уужим орд ХХК-с тус бүр 25000,0 мянган төгрөг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн.

Эм Эл Цахиурт Овоо ХХК-ний дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баясгалант цэцэрлэгт хүрээлэнгийн 480 метр хашааг Улаанбаатар хотын “Бат Луу” ХХК-р 13 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа сурагчдын дотуур байрын барилгын ажил суурийн цутгалтын ажил 100 хувь хийгдэж, өрлөгийн ажил 07 дугаар сарын 20-ны өдрөөс эхэлсэн. \Гүйцэтгэгч Велмот ХХК\

Сунхунголд ХХК-ны техникийн тусламжтайгаар сумын төвийн газарт орсон барилгуудын туурийг цэвэрлүүлэх, нэгдсэн хогийн цэгийг чөлөөлөх ажилд орон нутгийн хөрөнгөөр 2204,000 төгрөг зарцууллаа.

Жишиг хорооллын ундны худагт “Монвекум” ХХК 9,6 сая төгрөгөөр цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан. Цэцгийн мандлын үрсэлгээг 800.000 төгрөгөөр авч хийлээ. Баяр наадмын зардалд Засаг даргын нөөц сангаас 10 сая төгрөг зарцуулсан. Тэгш, Дэлгэр багийн төвийн барилгын ажил дуусч актаар хүлээн авсан. Багуудын нээлт 8 сарын 9, 10-ны өдрүүдэд болохоор төлөвлөгдсөн. Жавхлант багийн төвийн барилгыг уурхайтай хамтран ажиллах гэрээний дагуу Шарга ХХК-аар гүйцэтгүүлж байна.

Ахмад, хүүхэд, залуучуудын тоглоомын талбай барих ажлын тендерийг цахимаар зарлаж нэг ч тендер ирүүлээгүй учраас “ЛХАТОНОМ ХХК”-тай шууд гэрээ байгуулаад байна.

Сумын хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3 уурхай байдаг Шинэ уужим орд ХХК-ны хувьд иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч үйл ажиллагаа нь түр зогссон.

Сун Хунгоульд ХХК- ний менежментийн төлөвлөгөөг дахин хэлэлцэж үнэлгээг өгсөн. Байгаль орчин аялал жуулчлалын газраас Баянцогтын булгийн эхийг хашихаар болж гүйцэтгэгчээр нь “Хөшөөтийн нам булаг” ХХК шалгарсан.

“Хандлагаа өөрчлөө, Цэвэрхэн наадацгаая” уриатай 150 ширхэг логог иргэдэд тарааж сурталчлан сумын баяр наадам, уул овооны тахилга наадмуудаар 6 иргэнийг 220000 төгрөгөөр урамшуулан ажиллуулж нийт 2 тонн гаруй хог хаягдал цэвэрлэсэн.

Шувуу барьж байна гэсэн мэдээллийн дагуу цагдаагийн хэсэгтэй хамтран 28-69 УБН улсын дугаартай ланд 80 маркийн машиныг шалгахад “Зэрлэг амьтан судлах төв”-

ийн баг Монгол орны цахилгаан дамжуулах агаарын шугамд цохиулж үхсэн шувуудын судалгаа авч дээж цуглуулах ажлыг гүйцэтгэж байсан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Монгол бичгээр 4-5 дугаар ангийн 8 хүүхдэд 70 цаг, математикийн хичээлээр 2-5 дугаар ангийн 18 хүүхдэд 42 цаг, 6-9 дүгээр ангийн 25 хүүхдэд 50 цагийн сургалтыг тус тус явуулсан. Мөн бага ангийн 5 багшид матемтакийн 20 цагийн сургалтыг зохион байгуулав.

07-р сарын 05-ны өдөр сумын баяр наадмын хүндэтгэлийн хурал, Саран ээж нийгэмлэгтэй хамтран "Хүний маань дээд ээж минь билээ" арга хэмжээг зохион байгуулав. Мөн "Наадмын дэнж" задгай шоу баяр наадмын "Хүндэтгэлийн тоглолт"-ыг зохион байгууллаа.

07-р сарын 17-нд "Ань" овогтны төрөл төрөгсдийн уулзалт, сумын заан Ганхуягт хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа, 07-р сарын 20, 21-ний өдрүүдэд Монгол Улсын мэргэн Н.Гантулгыг алдаршуулах Шагайн тойром тэмцээнийг зохион байгуулж УБ хот, Хэнтийн Бор-Өндөр зэрэг сумдаас 13 баг оролцсон.

"Өсвөрийн номын санчид" дугуйлангийн сурагчдын зөөврийн номын сангийн аяны "ХАМТДАА ХӨГЖЬЕ, ХАМТДАА УНШЪЯ" хүрээнд 58 иргэнд шинээр карт нээж 136 номоор үйлчилгээ хүргээд байна.

_____Амбулаторид 85 урьдчилан сэргийлэх үзлэгээр 1 хүн, идэвхитэй диспансерийн хяналтад 10, гэрийн идэвхтэй хяналтад 2, нийт 35 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүллээ. Жирэмсний эрт хяналт 88,8, 0-5 насны 20 хүүхдийг хяналтад үзэж жинлэж, урьдчилан сэргийлэх тарилгад хамруулсан.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Олон нийтийн мэдээллийн цагаар Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн талаар, Сум хөгжүүлэх сангийн журам, Угийн бичиг хөтлөх журам, Нийгмийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар эрх зүйн сургалт 4 удаа сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж 256 иргэн хамрагдсан. Мөн урсдаг самбар, байгууллагуудын мэдээллийн самбар зэргээр шинээр батлагдсан хууль журмын талаар иргэдэд мэдээлэл өгч хэвшсэн. Иргэдийн санал хүсэлт, мэдээллийг түргэн шуурхай хүлээн авдаг тусгай дугаарын /98514040/ утсыг 2013 оноос эхлэн ажиллуулж иргэдийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байна.

Сар бүрийн 1, 11, 21, 31-нд архи, согтууруулах ундаа худалдахыг хориглосон сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд 7 сард Цагдаагийн хэсэгтэй хамтарч шалгалт явуулсан. Захирамжийг зөрчсөн зөрчил гараагүй байна.

Ундны худагт машин угаасан иргэнийг Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч 100,000 төгрөгийн торгууль ногдуулсан.

11. Сүхбаатар сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/353 дугаар захирамжийн дагуу Ардын хувьсгалын 98-н жил, сум байгуулагдсаны 95-н жил, сумын Эрүүл мэндийн төвийн 80-н жилийн ойн баяр наадмыг 07 дугаар сарын 05, 06, 07-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Сумын ИТХ-ын тогтоолоор баяр наадмыг зохион байгуулах 10-н дэд хороо байгуулагдаж хороо бүр хийх ажлаа төлөвлөж наадмын бэлтгэл ажлыг ханган ажилласан. Үүний хүрээнд сумын Засаг даргын 2019 оны А/103 тоот захирамжаар 07 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд сумын төвийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мопед, мотоциклын хөдөлгөөнийг түр хориглон хэрэгжүүлэн ажилласан. Мөн баяр наадмын хүрээнд “Монголын нууц товчоо” их хөлгөн судар 180 метр даавуун бүтээлийг санаачлагч, зохиолч, сэтгүүлч Хонхэрэйд овогт Б.Энхбат төрөлх сумандаа 07.06-ны өдөр уг бүтээлээ дэлгэн толилуулсан.

Сумын ИТХурал, ЗДТГазраас Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Навааншаравын Осгон “Хөдөлмөрийн баатар” цол хүртсэний 30-н жилийн ой, алдрыг тэмдэглэх баяр наадмыг 07 дугаар сарын 31-нд тэмдэглэн өнгөрүүлэхээр бэлтгэл ажилдаа орон ажиллаж байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын 2019.07.03-ны өдрийн 6/925 тоот албан бичгийн дагуу сумын 2020 оны төсвийн төсөл, 2021-2011 оны төсвийн төсөөллийг боловсруулан бэлтгэж хүргүүлсэн. Мөн 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаа байгууллага бүр Э-тайлан программд шивж оруулаад байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын 1-р багт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудыг дайчлан сумын нэгдсэн хогийн цэгийн тэлсэн хогыг түрүүлж цэгцлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн сумын баяр наадам болохтой холбогдуулан 07 дугаар сарын 04-нд “Нэг өрхөөс нэг иргэн нийтийн цэвэрлэгээнд” уриан дор бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулсан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нью Дарьганга зусланд зорилтод өрхийн 8-н хүүхдийг амрааж, ЭМБС-аас 1,2 сая төгрөг зарцуулсан.

06-р сарын 27, 28-нд аймагт зохион байгуулагдсан “Гэр бүлийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт зөвлөгөөнд сумаас 6-н эмэгтэй оролцсон. Аймгийн Жаахан шарга театрын ерөнхий зураач МУСТА " ГЭГЭЭН МУЗА" академийн тэргүүн шагналт Санжаагийн Гантулга “ТАЛЫН САЛХИ” уран бүтээлийн үзэсгэлэнгийн нээлтээ 07 дугаар сарын 06-нд сумын музейд зохион байгууллаа.

Сум байгуулагдсаны 95 жилийн ой, сумын Хүн эмнэлэг /одоогоор Эрүүл мэндийн төв/ байгуулагдсаны 80 жилийн ойг угтан "Айл бүхэн - Ариун цэврийн байгууламжтай болцгооё" уриан дор нэг сарын болзолт уралдааныг сумын төвд амьдарч байгаа айл өрхүүдийн дунд зарлаж шалгаруулсан.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Канад улсын ГХЯ-аас хэрэгжүүлж буй уул уурхайн салбарт мэрит буюу олон нийтийн оролцоо сэдэвт төслийн сургалт 06.25-нд суманд зохион байгуулагдсан ба уг сургалтад хөдөөгийн малчид, иргэдийн төлөөлөл болон холбогдох албан тушаалтнууд хамрагдсан.

13. Эрдэнэцагаан сарын ажлын товч мэдээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Монгол тулгар төр байгуулагдсаны 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 813 жил, Ардын хувьсгалын 98 жил, Эрдэнэцагаан сум байгуулагдсаны 95 жилийн ой Үндэсний их баяр наадмаа 2019 оны 07 дугаар сарын 06,07-ны өдрүүдэд зохион байгууллаа. Баяр наадмын үйл ажиллагааг зохион байгуулах Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 07 дугаар сарын ... өдрийн .. тоот тогтоолоор Ерөнхий зохион байгуулах комиссоос гадна 5 комиссыг холбогдох албан хаагчдын бүрэлдэхүүнтэй баталж Орон нутгийн 5 сая төгрөгийн төсвөөс гадна Адаэ ХХК-ны 5 сая төгрөгийн хандиваар Соёл урлагийн үйл ажиллагааны нээлт хаалтын үйл ажиллагаанд зарцуулж ажиллалаа. Баяр наадмын хүндэтгэлийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулж Төрийн шагналыг гардууллаа. Үүнд Сумын засаг даргын баярын бичгээр 2 иргэн, Сумын засаг даргын жуух бичгээр 4 иргэн, Аймгийн засаг

даргын баярын бичгээр 5 иргэн, Жуух бичгээр 6 иргэн, Уяачын алдар цол тэмдгээр 2 уяач, ХААХҮяамны жуух бичгээр 3 иргэн, Барилга хот байгуулалтын яамны Тэргүүний барилгачин тэмдгээр 2 иргэн, Банк санхүүгийн тэргүүний ажилтнаар 1 иргэн, Нийгмийн даатгалын Ерөнхий газрын жуух бичгээр 1 иргэн, Хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрийн тэргүүний ажилтнаар 11, нийт 37 иргэн төр засагт хөдөлмөрөө үнэлүүлж шагнууллаа.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сумын татварын орлогын мэдээг сар бүр авч тулган Жилийн төлөвлөгөөт орлого 140.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 7 сарын байдлаар нийт 84.6 сая төгрөгийг төвлөрүүлж биелэлт 120%-тай байна.

2019 оны ОНХСангаар нийт 25 ажлыг 625,3 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэхээр баталсны дагуу 7 сарын байдлаар батлагдсан жагсаалтын дагуу Соёлын төвийн зүүн талын талбайн тохижилтын ажлыг дуусгаж үлдэгдэл 23.7 сая төгрөгийг шилжүүлж,

Сумын төвийн 2 ундны усны худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж, автомат худгийн тоног төхөөрөмжийг суурилууллаа. Ажлын хүрээнд худаг тус бүрд 5 шүүлтүүртэй ус цэвэршүүлэх төхөөрөмж, 24 цагийн автомат карт уншуулах тоног төхөөрөмж, камержуулалт, гэрэлтүүлгийг байршуулж 600 ширхэг картыг иргэдэд тараасан. Уг ажлыг 2019 оны ОНХС-н 36 сая төгрөгөөр Баялаг говь ХХК хийж гүйцэтгэж ажил хүлээлцэх ажлын хэсэг 100% хүлээж авсан.

Сумын төвийн камержуулалтын өргөтгөлийг ОНХС-н 5 сая төгрөгөөр, хүүхдийн 2-р цэцэрлэгийн камержуулалт 5 сая төгрөг, Соёлын төвийн камержуулалтыг 5 сая төгрөгөөр Баялаг говь ХХК хий гүйцэтгэн хүлээн өглөө.

ОНХС-н 7 сая төгрөгийн хөрөнгөөр Аймгийн нэгдсэн эмнэлгийн газартай хамтран ажиллаж 9 төрлийн нарийн мэргэжлийн чиглэлээр үзлэг зохион байгуулж үзлэг шинжилгээнд 3700 хүнийг хамруулж, 15-49 насны иргэдэд БЗДХ-н өвчлөл илрүүлэх, эмчлэх зорилгоор нийт 2193 хүнийг хамруулж хамрагдалт 57,7 хувьтай байна.

7 сарын байдлаар нийт 6 ажлын 81,7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажиллаад байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 200 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийн барилгын ажлыг Хар үжин ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 7 сарын байдлаар 20 хувьтай байна.

2019 оны Орон нутаг хөгжүүлэх сангийн 40 сая төгрөгийн хөрөнгөөр Талын зам ХХКомпани сумын төвийн айл өрхийн гудамж талбайн замыг хайрган хучилттайр засварлаж 4 км замыг засварлаж ажиллалаа.

Мөн Талын зам ХХК нь хатуу хучилттай зам дагуу 400 метр явган хүний зам засварын ажлыг хийж гүйцэтгэн ажлын гүйцэтгэл 75 хувьтай байна.

2019 оны 07 дугаар сарын байдлаар ЕБСургуулийн сантехник бусад завсарын 100 сая төгрөгийн ажлын тендер, Эрүүл мэндийн төвийн 20 сая төгрөгийн завсар тохижолтын ажил, Сумын төвийн авто зам дагуу 40 сая төгрөгийн гэрэлтүүлгийн ажил, Айл өрхийн гудамжны гэрэл гэрэлтүүлгийн 40 сая төгрөгийн ажлын тендерүүд зарлагдаад байна.

Бэлчээрийн менежмент төслийн хүрээнд ЗДТГ-т бүртгэлтэй сүрлэн байшинг /хуучин насан туршийн боловсролын нэгж, иргэний танхим байрлаж байсан/ 32 сая төгрөгөөр засварлах ажил хийгдэж ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна.

Аймгийн Байгаль орчны газар болон Сумын ЗДТГ хамтран Сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэр Зотол хан уулын орчимд эр 9, эм 11 нийт 20 толгой тарвага нутагшууллаа.

Орчны бохирдол, төв замын арчлалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдөр Төсвийн 5 байгууллага 2 аж ахуй нэгж айл өрхүүдтэй хамтран Төв зам дагуу ургасан зэрлэгийг зулгааж 2 км хатуу хучилттай замын шороог цэвэрлэлээ үүнд 5 байгууллагын 63 албан хаагч 2 аж ахуй нэгжийн 8 иргэн 35 өрхийн 57 иргэн нийт 128 хүн хамрагдсан. Мөн 07 дугаар сарын 24-ны өдөр 29 ахмад настан Сумын төв цэцэрлэгт хүрээлэнгийн зэрлэгийг зулгааж цэвэр орчинг бүрдүүлээ.

8-н багийн малчидтай хамтран Бэлчээрт хөнөөл учруулж байгаа үлийн цагаан оготной тэмцэх ажлыг 6000 га газарт энгийн механик, биологийн аргаар 13,734,800 төгрөгийн санхүүжилтээр хийгээд байна.

2019 оны 07 сарын байдлаар нийт 43722 адуунаас 7860 хамрагдалт 35%, нийт 28212 үхрээс 2251 хамрагдалт 15%, нийт 287098 бог малаас 47663 толгой малыг туулгалтад хамруулж хамрагдалт 33 хувьтай байна. Гадна шимэгчлэгч празитын

эсрэг бог малын угаалгын ажил хийгдсэн бөгөөд нарийн тоон үзүүлэлт гарч амжаагүй байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Улсын бүртгэлтийн Ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт орж шинээр батлагдсантай холбогдуулан олон улсын чиг хандлагад нийцүүлэн онлайн системд холбогдон үйлчилгээний чанар стандартыг мөрдөн ажиллаж 2019 оны 07 сарын байдлаар Төрсний бүртгэлд 50 хүүхэд бүртгүүлж гэрчилгээ авсанаас 18 эмэгтэй, 38 эрэгтэй хүүхэд, Гэрлэлтийн бүртгэлд нийт 15 гэр бүл бүртгүүлж гэрчилгээ авсан. Нас барсны бүртгэлд 16 иргэн бүртгүүлснээс эмэгтэй 4, эрэгтэй 12 иргэн нас барж ар гэрт нь гэрчилгээ бичиж олгоод байна. Эцэг тогтоосны бүртгэлд 5 хүүхэд бүртгүүлснээс хуучин эцэг тогтоосны бүртгэлд 2, шинээр 3 иргэн бүртгүүлсэн. Овог нэр солилтын бүртгэлд 1 иргэн бүртгүүлсэн байна. Гэрлэлт цуцалсны бүртгэлд 5 гэр бүл бүртгүүлж гэрлэлтээ цуцлуулсан. Иргэний шинэчилсэн бүртгэлд 138 иргэн хамрагдаж шилжин ирсэн 55 иргэн, үрчлэлтийн бүртгэлд 2 хүүхэд бүртгүүлж иргэний үнэмлэх дахин олголтод 24 хүн хамрагдсан байна.

2019 оны 7 сарын байдлаар амьжиргааг дэмжих зөвлөлийг 11 удаа хуралдуулж байнгын асаргааны сунгалт хийлгэх 45 хүсэлт ирснийг 100% шийдвэрлэсэн. Шинээр асаргаанд орох хүсэлттэй 8 иргэн, 2 ХБХүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн.

малжуулах төсөлд нийт 6 өрх материалаа ирүүлснээс 3 өрх төсөлд хамрагдсан. \Сумын хэмжээнд төсөлд хамрагдах боломжит тоон үзүүлэлт 3 байсан\

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдах хүсэлттэй 20 өргөдлөөс 5 өрхийг хамруулсан.

Төсөл хөтөлбөрүүдэд 2 төслийн нийт 3,5 сая төгрөгийн санхүүжилтыг олгож 3 ажлын байрыг бий болгосон.

2019 оны 07 сарын байдлаар

Ажил олгогч шинээр 2 хамруулж жилийн төлөвлөгөө 200%

ЭМД-д 683 хүн хамруулж жилийн төлөвлөгөө 40%

СДД-д – 385 иргэн хамруулж жилийн төлөвлөгөөний 74%-ийг тус тус биелүүлж ажиллалаа.

Шимтгэлийн орлогын төлөвлөгөөг төрөл тус бүрээр сар, улирал, жилээр жигд ханган биелүүлэх чиглэлээр хөдөөгийн 5 баг, сумын төвийн 1 багт суурь тойрон ажиллаж хуулийн сурталчилгаа хийж ажилласан.

А/О-с жилийн-810502.9 м/т, хагас жилийн 388684.8- 494083,1 мянган төгрөг орж жилийн төлөвлөгөөний биелэлт 61%-тай, 7 сарын байдлаар төлөвлөгөөний биелэлт 127,1%-тай, СДД-с жилийн- 155043.2 м/т, 7 сарын байдлаар 80064.3- 110721,2 орж жилийн төлөвлөгөөний биелэлт 71,4%-тай, 7 сарын байдлаар төлөвлөгөөний биелэлт 138,2%-тай, ЭМД-с жилийн 41712,0 м/т, 7 сарын байдлаар 24317,8- 27864,4 мянган төгрөг оруулж жилийн орлогын төлөвлөгөөний биелэлт 66%-тай, 7 сарын байдлаар төлөвлөгөөний биелэлт 114,5%-иар тус тус биелүүлж ажиллалаа. Орлогын зарцуулалтыг хуулийн дагуу зарцуулж мэдээ, тайланг гаргаж байна.

Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь хувилбарт сургалтаар 15 хүүхэд, Зуны буюу нүүдлийн цэцэрлэгт 75 хүүхдийг хүлээн авсан.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаанаар ахлуулсан ажлын хэсэг суманд ажиллаж Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт, шинэчлэлтийн талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулж 67 төрийн албан хаагч 8-н багийн 72 иргэн хэлэлцүүлэгт хамрагдлаа. Хэлэлцүүлгээр 14 иргэн санал хүсэлт тавьж, асуултад хариулт авлаа.

Мөн Монгол улсын үндсэн хуулийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан “Сургагч багш” бэлтгэх онлайн сургалтад сумын Засаг даргын Тамгын газрын дарга, ХШҮ, эрх зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нар 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдөр аймагт очиж 1 өдрийн сургалтад хамрагдсан.

Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар иргэд, төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.